

**Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн
хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, 2022 оны эхний 11 сарын байдлаар,
Эрүүл мэндийн яам**

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
НЭГ. КОВИД-19 ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО								
1	1.1.2. КОВИД-19 халдварт цар тахлын эрсдэлээс урьдчилан сэргийлж, бэлэн байдлыг хангахтай холбоотой төсвийн санхүүжилтийг нэмэгдүүлнэ	7.Коронавируст халдвар (КОВИД-19)-тай холбоотой хийгдэх судалгааны ажлын тэргүүлэх чиглэлийг батлуулах, судалгааны ажил болон санхүүжилтийг шийдвэрлүүлж, үр дүнг хүлээн авна.	2020-2024	600.0 Улсын төсөв (Шинжлэх ухаан технологийн сан)	Монголд Улсад зөөвөрлөгдөж ирсэн коронавируст халдварын геномын бүтцийг тодорхойлсон байна. Эмнэлзүйн онцлог тодорхойлогдсон зөвлөмж, зааварт тусгагдсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/620 тушаалаар Коронавируст халдвар (COVID-19)-ын судалгааг зохион байгуулах удирдах ажлын хэсэг, судалгааны тэргүүлэх 10 чиглэлийг боловсруулж батлуулсан. 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хурлаар судалгааны ажлын үр дүнгийн даалгавар танилцуулгыг батлуулж судалгааны ажлууд эхэлсэн. Судалгааны ажлын санхүүжилтийг 2021 оны төсвийн тодотголоор 2.4 тэрбум төгрөгийг батлуулсан. “КОВИД-19 вакцинжуулалт болон халдварын дараах SARS-CoV-2 вирусийг саармагжуулах идэвхийн судалгаа”, “КОВИД-19 эсрэг вакцины гурав дахь сэргээх тунгийн дараах дархлааны хариу урвал болон дархлаажуулалтын дараах урвал хүндрэлийг судлах нь”, “Монгол Улсад КОВИД-19 цартахал үүсгэсэн SARS-CoV-2 вирусийн геномын шинжийг судалсан судалгаа”-ны дүн гарсан. 2022 оны 11 дүгээр сард судалгааны ажлын үр дүнг хүлээн авч, хэвлүүлсэн.	БТГ-СТХ I улирал	90.0
2		8.Олон улсын байгууллагатай хамтарсан коронавируст халдвар (КОВИД-	2020-2024	800.0 Олон улсын байгууллага (ДЭМБ)	Хүн амын коронавируст халдварын тархалтыг ийлдэс судлалын	Коронавируст халдвар (COVID-19)-ын тархалтыг хүн амд суурилан, насны бүлэг тус бүрээр судлах тархвар зүйн судалгааны ажлыг эцэслэж, ном болгон хэвлүүлж хүлээн авсан байна.	БТГ-СТХ I улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
		19) судалгааны ажлуудыг эхлүүлэх, үр дүнг хүлээн авна			аргаар тодорхойлсон байна.			
3				20.0	Эмнэлзүйн зураглал, өвчний явц, халдвартай тохиолдлуудын хугацааг тодорхойлсон байна.	Монгол Улсад бүртгэгдсэн шинэ коронавируст халдвар (КОВИД-19)-ын эмнэлзүйн судалгааг 2021-2022 онд хэрэгжүүлж, судалгааны ажлын эцсийн үр дүнг 2022 оны 11 дүгээр сард хүлээн авч, хэвлүүлсэн.		100.0
4	1.1.3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хариу арга хэмжээний бэлэн байдлыг хангана.	1.Хариу арга хэмжээний нөөцийн бэлэн байдлыг бүрдүүлнэ.	2021-2024		Нийгмийн эрүүл мэндийн байдлын нөөцийн байдлын хийгдэж, шинэчилж байна.	Цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээнд хэрэглэх нөөцийг гадаад эх үүсвэрээс дараах байдлаар бүрдүүлж ажилласан байна. Үүнд: 1. Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан 50,166,400 төгрөгийн үнэ бүхий 3,200 ширхэг моксифлоксациныг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон. 2. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавирусын халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 1,791,815,400 төгрөгийн үнэ бүхий 10 ширхэг унтуулгын аппарат болон дагалдах хэрэгслийг 01 дүгээр сард хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн. 3. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 17,008,368 төгрөгийн	НЭМГ-УСХЗХ, ТЗУГ-ГХХ I-IV улирал	90.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>үнэ бүхий суурилуулах 6 ширхэг эмнэлгийн зориулалт бүхий хөргөгч, 57,036,754 төгрөгийн үнэ бүхий эм болон эмнэлгийн хэрэгслийг 02 дугаар сард хүлээн авав.</p> <p>4. НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 85,950,000 төгрөгийн үнэ бүхий 6,000 ширхэг нэг удаагийн халатыг 02 дугаар сард хүлээн авч нөөцөд авах тухай тушаал батлуулсан.</p> <p>5. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 1,799,583,040 төгрөгийн үнэ бүхий эх, нярайн тусламж үйлчилгээнд ашиглагдах эмнэлгийн тоног төхөөрөмжийг 02 дугаар сард хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгөв.</p> <p>6. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 595,954,440 төгрөгийн үнэ бүхий явуулын эмнэлэгт суурилуулах эмнэлгийн тоног төхөөрөмжийг хүлээн авч 3 дугаар сард хуваарилсан.</p> <p>7. “КОВИД-19 халдвартай тэмцэх эм, эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгслийн хангамжийг дэмжих АСТ-А SFF” механизмын санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаас 862,312,500 төгрөгийн үнэ бүхий 787,500 ширхэг дексаметазон тариаг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>8. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 3,849,487,680 төгрөгийн үнэ бүхий 12 ширхэг С хэлбэрт рентген аппаратыг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн.</p> <p>9. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 145,555,972 төгрөгийн үнэ бүхий 2 генийн дараалал тогтоогч 9,795,520 төгрөгийн үнэ бүхий генийн дараалал тогтоох шинжилгээний өгөгдлийг унших 2 зөөврийн компьютер, тог баригч, 207,023,772 төгрөгийн үнэ бүхий урвалжуудыг хүлээн авч УНТЭ болон ЗӨСҮТ-д тус тус хуваарилан өгсөн.</p> <p>10. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд дархлаажуулалтын бүртгэл мэдээллийг сайжруулах зорилгоор 1,246,715,344 төгрөгийн үнэ бүхий 548 ширхэг зөөврийн компьютер болон дагалдах хэрэгслийг хүлээн авч улсын хэмжээнд дархлаажуулалтын цэгүүдэд хуваарилан өгсөн.</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>11. НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 356,933,850 төгрөгийн үнэ бүхий хувийн хамгаалах хэрэгслүүдийг хүлээн авч нөөцөд авах тухай тушаалыг батлуулсан.</p> <p>12. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 33,250,000 төгрөгийн үнэ бүхий 42 ширхэг пульсоксиметрыг хүлээн авч холбогдох эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилсан.</p> <p>13. Япон Улсын Засгийн газрыг “Эдийн засаг, нийгмийн хөгжлийг дэмжихэд чиглэсэн хөтөлбөр”-ийн хүрээнд Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдалтай холбогдуулан Монгол Улсад эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл нийлүүлэх Төслийн бус буцалтгүй тусламжийн хүрээнд 1,200,011,300 төгрөгийн үнэ бүхий 5 ширхэг уушгины дуран, 3 ширхэг уушгины мэс заслын багаж хэрэгслийн багцыг хүлээн авч ХӨСҮТ-д хуваарилан олгосон.</p> <p>14. 2021 оны 12 дугаар сард хүсэлт тавьсны мөрөөр НҮБ-ын Хүүхдийн сангаас буцалтгүй тусламжийн хүрээнд 847,350,000 үнэ бүхий 787,500 ширхэг дексаметазон тариаг хүлээн авч эрүүл мэндийн байгууллагуудад хуваарилан олгосон.</p> <p>15. Олон талт хамтын ажиллагааны КОВАКС механизмын хүрээнд SARS-CoV-2 халдварын эсрэг 5-11 насны хүүхдийн вакцин авах хүсэлтийг 2022 оны 04 дүгээр сард КОВАКС-д албан ёсоор хүргүүлж,</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээн ний хувь, %
						<p>улмаар 2022 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нийт 1,030,000 тун 5-11 насны хүүхдийн вакциныг Монгол Улсад олгохоор шийдвэрлэсэн тухай албан хариуг хүлээн авсан. Вакцин хүлээн авахтай холбоотойгоор тариур, аюулгүйн хайрцаг зэрэг дагалдах хэрэгслийг КОВАКС-аас авах хүсэлтээ мөн өдөр НҮБ-ын Хүүхдийн санд хүргүүлсэн. Вакцин, тарилгыг найруулах уусмалыг АНУ-ын Засгийн газрын буцалтгүй тусламжаар олгож байгаа ба олон улсын тээвэр, даатгал, дагалдах хэрэгслийг КОВАКС хариуцаж хангалт хийж байгаа.</p> <p>2022 оны 6 дугаар сарын 15-ны өдөр тарилгын уусмалыг, 18-ны өдөр эхний ээлжийн 302,400 тун вакциныг тус тус хүлээн авсан.</p> <p>16. Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн санхүүжилтээр НҮБ-ын Хүүхдийн сангаар дамжуулан “КОВИД-19 цар тахал болон нийгмийн эрүүл мэндийн онцгой байдлын үеийн чадавхыг бэхжүүлэх” хөтөлбөр болон НҮБ-ын Хүүхдийн сангийн Улс орны (2017-2022)-ийн “Хүүхдийн эсэн мэнд амьдрахуй ба хөгжил” хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын Засгийн газарт олгосон 536,307,861 төгрөгийн үнэ бүхий 3 явуулын эмнэлэг, ариун цэврийн байгууламжийн чингэлэг, 908,367,975 төгрөгийн үнэ бүхий 3 явуулын эмнэлгийг хүлээн авч, эрүүл мэндийн салбарын нөөцийн агуулахыг хариуцаж байгаа ЗӨСҮТ-д Эрүүл мэндийн сайдын тушаалаар хуваарилан олгов. Эдгээр зөөврийн эмнэлэг, ариун цэврийн байгууламжийг хилийн боомтуудад ашиглах ба зөөврийн эмнэлэг тус бүрт эмнэлгийн зориулалтын</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>хөргөгч, эмийн багц, дефибрилятор, өвчтөний хяналтын монитор, зөөврийн ЭХО, амьсгалын аппарат, эмнэлгийн ор, пульсоксиметр, дуслын автомат шахуурга, тариурын автомат шахуурга, хүчилтөрөгч өтгөрүүлэгч суурилуулсан болно.</p> <p>17. НҮБ-ын Хүн амын сан, Люксембургийн Их Гүнт Улсын Засгийн газрын хамтарсан санхүүжилтээр Өргөө, Амгалан амаржих газар болон ЭНЭҮТ-II-т молекул биологийн иж бүрэн лаборатори байгуулж ашиглалтад оруулав. Зөвхөн КОВИД-19-ийн ПГУ шинжилгээ хийх бус бусад халдварт өвчний шинжилгээ хийх чадавхийг бүрдүүлсэн.</p> <p>18. НҮБ-ын Хүүхдийн сангаас Монгол Улсын Засгийн газарт буцалтгүй тусламжийн хүрээнд хувийн хамгаалах хэрэгсэл болох 20,000 ширхэг нэг удаагийн хамгаалалтын хувцасны иж бүрдэл, 100,000 ширхэг нэг удаагийн халад болон 20,000 ширхэг нүүрний хаалтыг хүлээн авч, ЭМЯ-ны нөөцөд авав.</p> <p>19. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд олгосон нийт 1,082,154,400 төгрөгийн үнэ бүхий 200 ширхэг спирометрийг 679,546,056 төгрөгийн дагалдах хэрэгслийн хамт хүлээн авч, Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/550 дугаар тушаалаар 21 аймгийн нэгдсэн эмнэлэг болон ЭМЯ-ны харьяа төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, НЭМГ-ын харьяа дүүргийн нэгдсэн эмнэлгүүдэд хуваарилан олгов.</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						20. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт “КОВИД-19 халдварт цар тахлын хямралыг арилгахад яаралтай тусламж үзүүлэх хөтөлбөр”-ийн буцалтгүй тусламжийн хүрээнд 5,3 тэрбум төгрөгийн үнэ бүхий 500,000 ширхэг түргэвчилсэн оношлуурыг хүлээн авч, Монгол Улсын 21 аймгийн нэдсэн эмнэлэг, БОЭТ, 331 сумын эрүүл мэндийн төв, НЭМГ-ын харьяа бүх эрүүл мэндийн байгууллагууд, ЭМЯ-ны харьяа болон бусад салбарын харьяаны КОВИД-ын тусламж үйлчилгээ үзүүлдэг бүх эмнэлэгт Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/556 дугаар тушаалаар хуваарилан олгосон.		
5		2. Шаардлагатай аймгуудад зоонозын өвчин судлалын төв, хил дагуух боомтод тандалтын нэгж байгуулна.	2021-2023	12,000.0 Улсын төсөв	2 аймагт Зоонозын өвчин судлалын төв хил дагуух 10 боомтод тандалтын нэгж байгуулсан байна.	2024 онд Дархан-Уул, Дорнод, Дорноговь, Төв аймагт 33 орон тоо бүхий “Зоонозын өвчин судлалын төв” болон хилийн 12 боомтод 8 орон тоо бүхий “Тандалтын нэгж”-ийг тус тус байгуулж, Ховд, Увс, Өмнөговь, Дундговь, Архангай аймгийн “Зоонозын өвчин судлалын төв”-д барилга, байгууламж барихад шаардагдах урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг шийдвэрлэх” Засгийн газрын тогтоолын төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн 1а/5053 тоот албан бичгээр ЗГХЭГ-т хүргүүлсэн.	НЭМГ-ХӨХ II, IV улирал	30.0
6		3. Шинэ болон сэргэн тархаж байгаа халдвараас сэргийлэх мэдээлэл, сургалт, сурталчилгаа зохион байгуулна.	2021-2024	100.0 Улсын төсөв	Төлөвлөгөөт сургалт, сурталчилгаа бүрэн хийгдсэн байна.	Коронавируст халдвар (КОВИД-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр бэлтгэх 94 инфографик, 2 видео шторк, 22 хөдөлгөөнт постерын эхийг бэлтгэн ЭМЯ-ны цахим хуудас болон фейсбуук хуудсанд байршуулан сурталчилж байна. Мөн сармагчны цэцэг өвчнөөс сэргийлэх чиглэлээр 2 текстэн зөвлөмж, 5 төрлийн	НЭМГ- ХӨХ, УСХЗХ I-IV улирал	70.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						инфографик бэлтгэн сурталчилгаанд ашиглаж байна. ЭМЯ-ны цахим хуудас, фейсбүүк хуудсаар түгээн сурталчилж, давхардсан тоогоор 47,693 хүнд мэдээлэл хүрч, 107 хүн хуваалцжээ.		
7		4.Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулах шинэчлэн барьж, ашиглалтад оруулна.	2020-2024	1,000.0 Гадаадын зээл, тусламж (АХБ)	Нөөцийн агуулах барилгыг барих тендерийг зарлаж, барилгын ажлыг эхлүүлсэн байна.	Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн нөөцийн агуулахыг Зоонозын өвчин судлалын үндэсний төв (ЗӨСҮТ)-ийн эзэмшлийн газрын баруун хойд хэсэгт 0.58 га. талбай бүхий Улаанбаатар хотын төв цэгээс 10 км зайд, Сонгинохайрхан, 20 дугаар хорооны нутаг дэвсгэрт Сонсголонгийн замын дагуу газарт шинэчлэн барьж, ашиглалтад оруулсан. Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 24-ны өдрийн А/331 дүгээр тушаалаар агуулахын тоног төхөөрөмжийг орлогод авч хуваарилан үндсэн хөрөнгийн бүртгэлд авсан байна.	СЭЗГ- ХОХ I-IV улирал	100.0
8		5.Өвчний хяналт, сэргийлэлтийн төв байгуулна.	2022-2024	1,000.0	Үндэсний түвшинд үйл ажиллагаа явуулах өвчний хяналтын төв байгуулагдаж, үйл ажиллагаа эхэлсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/229 дүгээр тушаалаар “Өвчний хяналт, сэргийлэлтийн төв” байгуулах хууль, эрх зүйн орчныг судлах, холбогдох дүрэм, журмын төсөл боловсруулах техникийн ажлын хэсэг байгуулагдсан. Уг ажлын хэсэг 2 удаа хуралдаж, мэдээлэл цуглуулах нэгдсэн асуулт, хүснэгт боловсруулж, эрүүл мэндийн байгууллагуудаас судалгаа авсан. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуулийн XIX.1.53-д Өвчтөний хяналт, зохицуулалтын төвийн барилга (Улаанбаатар, Баянзүрх дүүрэг)-ын ажил 3.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр батлагдаж, худалдан авах ажиллагааг 2022 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр зарласан. Барилгыг Нийгмийн эрүүл мэндийн	БТГ III улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						үндэсний төвийн хашаанд барихаар төлөвлөж байна.		
9		6.Шинэ коронавирусийн халдварыг тодорхойлох оношлуурыг дотооддоо бүтээн, туршиж, хэрэглээнд нэвтрүүлнэ.	2021-2024		Оношлуурын бүрдлийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.	“Чорос онош” ХХК-ний гаргасан коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх бхПГУ-ын тодорхойлох оношлуур, Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургуулийн гаргасан шүлсэнд коронавируст халдвар (КОВИД-19) илрүүлэх бхПГУ-ын тодорхойлох оношлуурын цомог, Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйлдвэрлэн гаргасан дархлаа дэмжих хүний хэвийн иммуноглобулиныг “Үндэсний багц” үүсгэн Ерөнхий гэрээнд оруулах чиглэлийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт 2022 оны 03 дугаар сарын 09-ний өдөр 5/1108 тоот албан бичгээр хүргүүлсэн. Энэхүү чиглэлийн дагуу ЭЭХХЗГ нь зах зээлийн үнийн судалгаа, 1 жилийн хэрэгцээг тооцоолон 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр ЭЭХХЗГ-ын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, даргын зөвлөлийн хурлын 2022/08 дугаар шийдвэрээр дээрх 3 бүтээгдэхүүнийг ерөнхий гэрээнд оруулах асуудлыг дэмжиж, хэрэгцээ, техникийн тодорхойлолт, босго үнийн саналыг тооцоолон Төрийн худалдан авах ажиллагааны газарт 2022 оны 04 дүгээр сарын 04-ний өдөр 02/01/703 дугаар албан бичгээр хүсэлтийг уламжилсан. 2022 оны 09 дүгээр сараас шүлсний оношлуурыг хэрэглээнд нэвтрүүлэн ажиллаж байна (АШУҮИС).	БТГ-СТХ IV улирал	100.0
10		7.Аймгийн нэгдсэн эмнэлэг, Бүсийн оношилгоо	2021-2024	500.0 Гадаадын зээл, тусламж	5 аймгийн НЭ, БОЭТ-д БХ-ПГУ төхөөрөмжтэй болж,	Булган, Төв, Дундговь аймагт молекул биологийн лабораторийг шинээр байгуулж ашиглалтад оруулснаар нийт 21 аймаг,	ЭТҮГ-ЭТЧАБХ	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
		эмчилгээний төвүүдийн Молекул биологийн лабораторийн чадавхийг бэхжүүлнэ			лабораторийн чадавх нэмэгдсэн байна.	нийслэлийн 8 дүүрэгт молекул биологийн лаборатори байгуулагдаад байна. Молекул биологийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг 202 лабораторид 2022 оны 04 дүгээр сард Олон улсын гадаад чанарын хяналтыг явуулсан. Түүнчлэн 2022 онд Люксембургийн Их Гүнт Улсын санхүүжилтээр “Цар тахлын үед эхийн болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, эрхийг хамгаалах” төслийг хэрэгжүүлж, Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө, Амгалан амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлэгт молекул биологийн шинжилгээ хийх иж бүрэн лабораторийг байгуулсан. Төслийн хүрээнд 109,726.76 ам.долларын үнэ бүхий 22 нэр төрлийн молекул биологийн оношилгооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслүүдийг лабораторийн стандарт тавилгын хамт хүлээлгэн өгсөн. Лаборатори нь КОВИД-ын халдвараас гадна нөхөн үржихүйн замын халдварууд, умайн хүзүүний хавдрын үүсгэгчийг илрүүлэх урвалж бодис, технологийн хамт нийлүүлэгдэж байгаагаараа онцлог. Нийлүүлэгч компани сургалтыг тоног төхөөрөмж болгоноор хийж, эмнэл зүйн сургалтыг ЭМЯ, Халдварт өвчин судлалын үндэсний төвтэй хамтран зохион байгуулсан.	I-IV улирал	
ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
2.1. Эрүүл мэнд. Өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг өргөжүүлж, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.								
11	2.1.1.Иргэдийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, иргэн бүр	1."Эрүүл, идэвхитэй амьдрал" арга хэмжээ хэрэгжүүлнэ	2021-2024	500.0	Арга хэмжээний хэрэгжилт 30 хувь	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалаар “Эрүүл, идэвхтэй амьдрал” 2021-2024 оны арга хэмжээний төлөвлөгөөнд 5 зорилт, 77 арга хэмжээ тусгагдсан бөгөөд 2022 онд нийт 75 арга	НЭМГ-ХБӨХ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх эрүүл мэндийн үзлэг,					хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 38.4 хувьтай байна.		
12	оношилгоонд тогтмол хамрагдах нөхцөлийг олон улсын жишигт нийцүүлэн сайжруулж, эрүүл идэвхтэй амьдралын хэв	2."Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх" арга хэмжээ хэрэгжүүлнэ	2021-2024	19,900.0 Улсын төсөв (ЭМДС)	Арга хэмжээний хэрэгжилт 50 хувь	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 31-ний өдрийн А/528 дугаар тушаалаар "Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх 2022-2025 оны арга хэмжээний төлөвлөгөөнд 8 зорилт, 166 арга хэмжээ тусгагджээ. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар 2022 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн 6/5075 тоот албан бичгийг эрүүл мэндийн байгууллагуудад хүргүүлсэн.	НЭМГ- ХӨХ I-IV улирал	30.0
13	маягийг төлөвшүүлэх үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлнэ.	3."Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэнд" арга хэмжээ хэрэгжүүлнэ	2021-2024	3,000.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж (НҮБ-ын Хүүхдийн сан)	Арга хэмжээний хэрэгжилт 40 хувь	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/760 дугаар тушаалаар батлагдсан "Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд" 2021-2024 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-нд 5 зорилт, 72 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 35.8 хувьтай байна.	НЭМГ- ХБӨХ I-IV улирал	70.0 (89.5)
14		4."Хавдрын эсрэг" арга хэмжээ хэрэгжүүлнэ	2020-2024	600.0 Улсын төсөв (ЭМДС)	Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралтын хүрэх түвшин 50 хувьд хүргэнэ.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/360 дугаар тушаалаар батлагдсан "Хавдрын эсрэг" арга хэмжээ төлөвлөгөөнд 6 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан бөгөөд 2022 онд 21 арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллаж байна. 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн байдлаар урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх үзлэгт улсын хэмжээнд 616,519 хүн хамрагдсанаас 279,213 буюу 45.3 хувь нь эрэгтэйчүүд, 337 306 буюу 54.7 хувь нь эмэгтэйчүүд байна. Үзлэгт хамрагдсан 18-60 насны хүн амаас хавдрын 184 сэжигтэй тохиолдол бүртгэгдсэн бөгөөд 31-45 насны ангилалд 49 тохиолдол буюу 26.6%, 46-60 насны ангилалд 135 тохиолдол буюу 73.4%	НЭМГ- ХБӨХ I-IV улирал	30.0 (37.2)

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						-ийг эзэлж байна. 31-45 насныхны дунд ходоодны өмөн 26.5%, хөхний өмөн 24.5%, элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 20.4%, 46-60 насны ангилалд элэг ба элгэн дэх цөсний өмөн 24.4%, ходоодны өмөн 24.4%, хөхний өмөн 10.4%-ийг тус тус эзэлж байна. 61-ээс дээш насны ангилалд хорт хавдрын 165 сэжигтэй тохиолдол бүртгэгдэж элэг ба элгэн дэх цөсний сувгийн өмөн 38.8%, ходоодны өмөн 26.7%, улаан хоолойн өмөн 15.2%-ийг тус тус эзэлж байна. Хорт хавдрын эрт илрүүлэх үзлэгийн хамралт 18.6 хувьтай байна.		
15		5."Элэг бүтэн Монгол" арга хэмжээ хэрэгжүүлнэ	2021-2024	13,000.0 Улсын төсөв (ЭМДС)	Арга хэмжээний хэрэгжилт 40-50 хувь хүрсэн байна.	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2024 онд хэрэгжүүлэхээр төслийг боловсруулж, ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. Арга хэмжээний төлөвлөгөөний төсөлд газар, хэлтсийн дарга нарын саналыг тусган, Эрүүл мэндийн сайдын тушаалаар батлуулахаар хүлээгдэж байна.	ЭТҮГ-АЛШТХ I-II улирал	0
16		6."Харшлаас сэргийлэх" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	200.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Арга хэмжээний хэрэгжилт 70 хувь хүрнэ.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/816 дугаар тушаалаар батлагдсан "Харшлаас сэргийлэх" арга хэмжээний төлөвлөгөөнд 4 зорилт, 48 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан. Арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 50.3 хувьтай байна.	НЭМГ-ХБӨХ IV улирал	70.0 (71.8)
17		7."Эрүүл чийрэг эрхүн" арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	500.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж (НҮБ-ын Хүн амын сан)	Арга хэмжээний хэрэгжилт 30 хувь хүрсэн байна.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/559 дүгээр тушаалаар батлагдсан "Эрүүл чийрэг эрхүн" арга хэмжээний төлөвлөгөөг 2021-2024 онд 4 зорилт, 46 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгасан байна. Арга хэмжээний төлөвлөгөөний	НЭМГ-ХБӨХ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						хэрэгжилт 2022 оны эхний 11 сарын байдлаар 35.0 хувьтай байна.		
18	2.1.2. "Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашиг, өгөөж, хүртээмжийг нэмэгдүүлж, элэгний вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ.	1."Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашгийн судалгаа хийнэ	2021-2022	Улсын төсөв	-	"Элэг бүтэн Монгол" арга хэмжээний үр ашгийн судалгаа хийгээгүй байна.		0
19	нэмэгдүүлж, элэгний вирусийн халдвартай иргэдийн 50-аас дээш хувийг эмчилгээнд хамруулж, хорт хавдрын эрт илрүүлгийг олон улсын жишигт хүргэнэ.	2.Д вирустэй Диргэдийг эмчилгээнд хамруулна	2021-2024	2,000.0 Улсын төсөв (ЭМДС)	Эмчилгээнд хамрагдах хувийг 30 хувьд хүргэнэ.	Хүний эмийн зөвлөлөөр элэгний Д вирусийн эсрэг "Bulevirtide (Hercludex)" эмийг өнчин эмийн жагсаалтад 2 жилийн хугацаатай бүртгэсэн. • Bulevirtide эм нь анх лиценз эзэмшигч MYR GmbH компанийн нэр дээр Европын эмийн агентлагт нөхцөлт зөвшөөрөл авсан бөгөөд эзэмшигчийн лиценз нь АНУ-ын Гилеад Сайенс компанид 2020 оны 12 дугаар сард шилжсэн. • Гилеад Сайенс компани 2021 оны 11 дүгээр сард АНУ-ын Хүнс эмийн агентлагт Bulevirtide эмийг бүртгүүлэхээр хүсэлт өгсөн. Урьдчилсан байдлаар 2022 оны 7-8 дугаар сард зөвшөөрөл гарахаар хүлээгдэж байна. Bulevirtide эмийн эмчилгээний талаар Гилеад Сайенс компаниас эмч нар 2022 оны 06 дугаар сарын 06-ны өдрөөс Монгол Улсад ирж эмийн талаарх мэдээлэл, сургалтын ажил хийхээр төлөвлөж "Омбол" ХХК-иас бэлтгэл ажлыг хийж байгаа талаар тус байгууллагаас мэдээлээд байна.	ЭТҮГ-АЛШТХ I-IV улирал	0
20	2.1.3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг	1.Эрхтэн шилжүүлэн суулгах төв байгуулна.	2022-2024	40,000.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц 30 хувьд хүрсэн байна. Төв ашиглалтад ороход шаардлагатай нөөцийн (хүний нөөц,	Эрхтэн шилжүүлэн суулгах төв нь Улаанбаатар хот Улсын нэгдүгээр төв эмнэлгийн хашаанд 60.2*30 м хэмжээтэй цоколийн 2 давхартай, 8 давхар барилгатай, шаардлагатай дэвшилтэт тоног төхөөрөмж, мэргэжилтнүүдээр	СЭЗГ-ХОХ I-IV улирал	0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	сайжруулан иргэд эх орондоо оношлогдон, эмчлүүлэх боломжийг нэмэгдүүлж, орчин үеийн үндэсний оношилгоо, эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна.				тоног төхөөрөмж, бусад) тооцооллыг хийсэн байна.	бүрэн хангагдсан байхаар төлөвлөгдсөн. Тус төсөл арга хэмжээний ТЭЗҮ боловсруулагдсан бөгөөд 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөг шаардлагатай. Санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Сангийн яаманд хүргүүлсэн.		
21	эмчилгээний төвүүдийг шинээр байгуулна.	2.Зүрх судасны төв байгуулна	2021-2024	40,000.0 Гадаадын зээл, тусламж	Барилгын ажлын явц 50 хувьд хүрсэн байна.	Зүрх судасны төвийн зураг төсвийг Люксембургийн Засгийн газрын дэмжлэгтэй хэрэгжиж байгаа “Зүрх судасны төв байгуулах” төслийн 1.5 сая еврогийн буцалтгүй тусламжаар Испани Улсын “Идом” ХХК гүйцэтгэж, барилга угсралтын ажлын дүн 122.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажсан. Барилгын төсвийн эх үүсвэрийг 2022 оны улсын төсөвт тусгах саналыг Сангийн яаманд хүргүүлсэн боловч батлагдаагүй, төсөвгүй гэх шалтгаанаар барилгын гүйцэтгэл гацсан байна. Төвийн барилгыг Улсын гуравдугаар төв эмнэлгийн хашаанд барихаар газрын асуудлыг шийдвэрлэсэн. Барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль болон гадаадын зээл тусламжаар хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.	СЭЗГ-ХОХ I-IV улирал	0
22		3.Сүрьеэгийн эмнэлэг барьж,	2021-2023	8,000.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц 2022 онд 60 хувьтай байна.	Сүрьеэгийн эмнэлгийн барилга угсралтын ажлын худалдан авах ажиллагааг зохион байгуулах ажил Засгийн газрын	СЭЗГ-ХОХ I-IV улирал	0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
		ашиглалтад оруулна				тогтоолоор Төрийн худалдан авах ажиллагааны газарт зохион байгуулагдаж, “Хар чонот” ХХК-тай гэрээ байгуулах зөвлөмж ирүүлсэн. Зөвлөмжийн дагуу гэрээний төсөл боловсруулах үед “Хар чонот” ХХК нь Сангийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Тендерт оролцох эрхээ хязгаарлуулсан этгээдийн бүртгэлд бүртгэх тухай” 213 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтад бүртгэгдсэн тул гэрээ байгуулах боломжгүй болж, тендерийг 2022 оны 08 дугаар сарын 12-ны өдөр дахин зарласан. Дахин зарласан тендерийг “Захиргааны актын биелэлтийг түтгэлзүүлэх тухай” Нийслэл дэх Захиргааны хэргийн анхан шатны Шүүхийн шүүгчийн 2022 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 128/Ш32022/7229 захирамжаар захиргааны хэргийг эцэслэн шийдвэрлэх хүртэл түр зогсоогоод байна. Барилгын ажлын төсөвт өртөг 18.5 тэрбум төгрөг бөгөөд 2022 оны улсын төсөвт 2 тэрбум төгрөгөөр суусан боловч ажил эхлээгүй. Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулийн дагуу хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.		
23		4.Геронтологийн төвийн барилгын ажлыг дуусгаж, ашиглалтад оруулна	2021-2022	5,600.0	Төв байгуулагдаж ашиглалтад орсон байна.	Монгол Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөрүүдээс эрүүл мэндийн салбарт Геронтологийн төвийн барилга царцсан, барилга угсралтын ажил хийгдээгүй байна. Барилга угсралтын ажлын зураг төсвийг бүрэн болгож, Барилгын хөгжлийн төвийн магадлалаар баталгаажуулахад төсөвт	СЭЗГ-ХОХ I-IV улирал	0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						өртөг нэмэгдсэн. Төсөвт өртгийн нэмэгдлийг Сангийн яаманд 2020-2022 онуудын төсвийн тухай хуульд тусгуулахаар өргөн барьсан боловч төсөвт өртөг нэмэгдэж батлагдаагүй. Монгол Улсын 2023 оны төсөвт тусгах саналыг Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлсэн.		
24		6.Халдварт өвчин судлалын үндэсний төвийн цогцолбор салбар II байгуулна	2021-2024	60,000.0 Улсын төсөв	Цогцолбор салбар II барилга баригдаж эхэлсэн байна.	Халдварт өвчин судлалын төвийн цогцолбор салбар байгуулах зураг төслийн ажлыг гүйцэтгэсэн. Төв аймгийн Сэргэлэн сумын 20 га газрыг Халдварт өвчин судлалын үндэсний төвд шилжүүлэн гэрчилгээг олгосон. 2023 оны төсвийн тухай хуулийн барилга байгууламжийн жагсаалтад санал хүргүүлсэн. Төсөвт өртөг 313 тэрбум төгрөгийн тооцоололтой байна. Барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслүүдэд санал хүргүүлсэн.	СЭЗГ-ХОХ I-IV улирал	0
25		7.Хавдар судлалын үндэсний төвийн салбар II байгуулна	2021-2024	30,000.0 Улсын төсөв	Барилгын ажлын явц 10 хувьд хүрсэн байна.	Монгол Улсын 2021 оны төсвийн тухай хуульд Барилга, хот байгуулалтын сайдын багцад зураг төсөв боловсруулах төсвийг тусгасан бөгөөд Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн даргын байгуулсан үнэлгээний хороо худалдан авах ажиллагааг зохион байгуулж, зураг төсвийн ажил 80 хувьтай үргэлжилж байна. Газрын асуудал шийдэгдэж, Баянзүрх дүүргийн Чулуутын аманд 10 га газарт барилга барихаар болсон. Барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэхээр Монгол	СЭЗГ-ХОХ I-IV улирал	0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслүүдэд санал хүргүүлэн ажиллаж байна.		
26		8. Баянзүрх дүүрэгт 300 ортой эмнэлэг барина.	2022-2024		Зураг, төсөв, ТЭЗҮ хийгдсэн байна.	Барилга, хот байгуулалтын сайдын багцад 268,9 сая төгрөгийн төсөвт өртөг тусгагдсан бөгөөд зураг төслийн гүйцэтгэгчийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, "Татах хүч" ХХК-тай гэрээ байгуулан зураг төсөв хийгдэж байна. Уг эмнэлгийн барилгыг барихаар олгогдсон 7,000 м ² газарт эмнэлгийн барилга багтахгүй байгаа тул газрын асуудлыг шийдвэрлүүлэхээр ажиллаж, мөн зураг төсвийн ажил хүлээгдэж байна. Барилга угсралтын ажлын санхүүжилтийг шийдвэрлэхээр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслүүдэд санал хүргүүлсэн.	СЭЗГ-ХОХ I-IV улирал	70.0
27		11.Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна	2021-2024		Батлагдсан зураг төслийн дагуу холболт хийнэ.	Сумын 10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 50 ортой Хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газраар 2021 онд баталгаажуулж, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 30 ортой сүрьеэгийн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулсан. Зургийг 2023 оноос эхлэн ашиглаж барилга байгууламжийг барина.	СЭЗГ-ХОХ I-IV улирал	70.0
28	2.1.4. Яаралтай тусламжийн чанар, үйлчилгээг олон	1.Орон нутагт шаардлагатай газарт яаралтай	2022-2023	5,000.0 Улсын төсөв	Орон нутагт шаардлагатай 10 цэгт яаралтай тусламжийн цэг байгуулсан байна.	Осол, гэмтэл ихээр гардаг Сүхбаатар аймгийн Түмэнцогт, Хөвсгөл аймгийн Хатгал, Баянхонгор аймгийн Бөмбөгөр, Булган аймгийн Хутаг өндөр, Архангай	ЭТҮГ-АЛШТХ I-IV улирал	90.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	улсын стандартад нийцүүлэн хөгжүүлнэ.	тусламжийн цэгт байгуулна.				аймгийн Тариат, Ховд аймгийн Булган, Завхан аймгийн Их-Уул, Орхон аймгийн Баян-Өндөр, Өвөрхангай аймгийн Хархорин, Сэлэнгэ аймгийн Мандал сум зэрэг 10 цэгт яаралтай тусламжийн жишиг цэгийг байгуулахад шаардлагатай тоног, төхөөрөмжийн худалдан авалтыг ДЭМБ-ын санхүүжилтээр хийж, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/502 дугаар тушаалаар эрүүл мэндийн байгууллагуудад тоног төхөөрөмжийг хуваарилсан. Эрүүл мэндийн төвийн эмч, мэргэжилтнүүдийг яаралтай тусламжийн тоног төхөөрөмж дээр ажиллах чадавхжуулах сургалтыг зохион байгуулахаар бэлтгэлийг хангаж байна.		
29		2. Эрүүл мэндийн байгууллагуудын яаралтай тусламжийн чадавхыг сайжруулж, техник, тоног төхөөрөмжөөр хангана	2021-2024	8,100.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Лавлагаа шатлалын 11 эрүүл мэндийн байгууллагын яаралтай тусламжийн чадавх бэхэжсэн байна.	Алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглах туулах чадвар өндөртэй түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг болон лавлагаа шатлалын Халдварт өвчин судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын гуравдугаар төв эмнэлгүүдэд нийт 4,1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгоод байна. Мөн түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгож ашиглалтад оруулаад байна. Япон Улсын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт Хөгжлийн төлөвлөлтийн техникийн хамтын ажиллагааны хүрээнд “Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II-ийн	СЭЗГ-ХОХ I-IV улирал	70.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						коронавируст халдвар КОВИД-19-ыг эмчлэх, урьдчилан сэргийлэх, эх хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг сайжруулах” төслийн хүрээнд 8 ширхэг иж бүрэн тоноглогдсон түргэн тусламжийн автомашиныг 2022 оны 08 дугаар сарын 15-ны өдөр хүлээлгэн өгчээ. ОХУ-ын Москва хотноо тус улсын Эрүүлийг хамгаалах яамны харьяа Хүүхдийн анагаах ухааны эрдэм шинжилгээний үндэсний төвд “Хүүхдэд яаралтай тусламж үзүүлэх зарчмууд” сэдэвт сургалтад Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Эх, нярай эмэгтэйчүүдийн үндэсний төв-II, Өргөө амаржих газраас нийт 15 эмч 2022 оны 07 дугаар сарын 11-22-ны өдрүүдэд оролцсон.		
30		3.Яаралтай тусламж, үйлчилгээнд агаарын үйлчилгээг (нисдэг тэрэг) нэвтрүүлнэ	2021-2022	11,200.0 Гадаадын зээл, тусламж	Яаралтай тусламжид нисдэг тэрэг нэвтрүүлж, үйлчилгээг төр, хувийн хэвшлийн гэрээний үндсэн дээр үзүүлж эхэлсэн байна.	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээлээр хэрэгжиж буй “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд хийгдэнэ. Уг төсөл нь 3 үе шаттай бөгөөд III үе шат буюу 2026 онд төсөл арга хэмжээ төлөвлөгдсөн бөгөөд судалгааны ажил хийгдэж байна. Гэмтлийн яаралтай тусламж, үйлчилгээнд ОБЕГ, хувийн хэвшлийн байгууллагатай иргэд хувиараа хамтран ажиллаж, нисдэг тэргээр тусламж, үйлчилгээ авч байна.	СЭЗГ-ХОХ I-IV улирал	30.0
31		4.Түргэн тусламжийн машины парк шинэчлэл хийнэ	2021-2024	8,500.0 Улсын төсөв	100 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна.	Алсын зайн болон яаралтай тусламжийн үйл ажиллагаанд ашиглагдах туулах чадвартай түргэн тусламжийн автомашиныг 21 аймаг болон лавлагаа шатлалын Халдварт өвчин судлалын үндэсний төв, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Зоонозын өвчин судлалын	СЭЗГ- ХОХ I-IV улирал	50.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						үндэсний төв, Эмгэг судлалын үндэсний төв, Эрүүл мэндийн хөгжлийн төв, Улсын гуравдугаар төв эмнэлэг зэрэг эрүүл мэндийн байгууллагад нийт 4.1 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгосон. Мөн түргэн тусламжийн УАЗ-фургон автомашиныг 11 аймгийн 22 сумын эрүүл мэндийн төвд 1.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр олгож, ашиглаж эхэлсэн. БНХАУ-ын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Улаан загалмайн байгууллагаас хандивласан Сөрөг даралтат түргэн тусламжийн 2 автомашиныг Монголын улаан загалмай нийгэмлэгээс 2022 оны 04 дүгээр сарын 12-ны өдөр ЭМЯ-нд хүлээлгэн өгсөн. “КОВИД-19” халдварын үед өвчтөн тээвэрлэх зориулалттай иж бүрэн тоноглогдсон энэхүү 2 автомашиныг ХӨСҮТ-д хуваарилсан байна. Уг машин дотор эмнэлгийн яаралтай анхны тусламжийн багаж, тоног төхөөрөмжийг суурилуулж өгсөн байна. Үүнд All6000S брендийн амьсгалын аппарат, Agison брендийн зүрхны цахилгаан бичлэгийн 12 сувагтай аппарат, дефибриллятор, хяналтын дэлгэц зэрэг зүйлс багтжээ. Нийт 50 эрүүл мэндийн байгууллагад түргэн тусламжийн автомашин олгосон байна.		
32	2.1.5. Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлж, хууль эрх зүйн орчныг бий болгоно.	1.Төрөлжсөн мэргэшлийн төв болон аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт эрүүл мэндийг дэмжих төв байгуулна	2021-2024	14,700.0 Улсын төсөв	2 дүүрэг, 5 аймгийн нэгдсэн эмнэлэгт Эрүүл мэндийн дэмжих төв байгуулна	“Эрүүл мэндийг дэмжих төв”-ийг 17 аймаг (Архангай, Орхон, Төв, Баянхонгор, Ховд, Хэнтий, Хөвсгөл, Өвөрхангай аймгийн Хархорин, Говь-Алтай, Дархан-Уул, Дундговь, Дорноговь аймгийн Замын Үүд, Сэлэнгэ, Булган, Увс, Завхан, Дорнод), 3 дүүргийн Эрүүл мэндийн төв (Баянзүрх,	СЭЗГ- ХОХ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						Багануур, Сонгинохайрхан), төрөлжсөн мэргэшлийн 3 эмнэлэг (УГТЭ, УХТЭ, УНТЭ)-т байгуулж нийт 1.2 тэрбум төгрөгийн өртөгтэй, 20 гаруй төрлийн иж бүрэн тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслээр хангасан. Нийт 12.1 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Увс, Завхан Булган, Дорнод, Говьсүмбэр, Сүхбаатар, Баян-Өлгий, Хөвсгөл, Сэлэнгэ зэрэг 9 аймагт 11.3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг зарцуулсан байна. Эрүүл мэндийг дэмжих төвийн засварын үйл ажиллагаа 100 хувийн гүйцэтгэлтэй байна.		
33		2.Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлосны шинэчлэн батлуулна	2021-2023	Улсын төсөв	Засгийн газрын тогтоолоор үндэсний товлосны шинэчлэн боловсруулна	Монгол Улсын хэмжээнд мөрдөх заавал хийх дархлаажуулалтын үндэсний товлосны шинэчлэн батлуулахаар Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах хуулийн өөрчлөлтийн төсөл, үзэл баримтлалын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүн, удирдамж, төлөвлөгөөг 2021 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/736 дугаар тушаалаар батлуулсан. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай үндэслэл, танилцуулга боловсруулсан. Дархлаажуулалтын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг 2022 оны 05 дугаар сарын 15-ны өдөр ЭМЯ-ны https://moh.gov.mn/news/5669 цахим хуудсанд 1 сарын хугацаатай байршуулжээ. Мөн Дархлаажуулалтын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварын үнэлгээ хийж, үнэлгээний дагуу үзэл баримтлалын төсөл, хуульд	НЭМГ- ХӨХ III-IV улирал	50.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						нэмэлт оруулах төсөл боловсруулсан. Дархлаажуулалтын тухай хуулийн төслийн үзэл баримтлалыг Сангийн сайд, Хууль зүй, дотоод хэргийн сайдаар 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр батлуулсан байна. Хуулийн төсөлд 15 яамнаас санал авч төсөлд саналыг тусган Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрлийг Сангийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яамнаас авсан бөгөөд хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр ЗГХЭГ-т 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 1а/5157 тоот албан бичгээр хүргүүлжээ.		
34		3.Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулахад дэмжлэг үзүүлнэ	2021-2024	3,000.0 Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн мэдээлэл, сургалт, сурталчилгаа, ухуулга нөлөөлөл, тандалт судалгааны ажлыг зохион байгуулна.	"Эрүүл мэндийг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах, хяналт тавих журам"-ын дагуу хүсэлт ирүүлсэн 280 төрийн бус байгууллагын төслийг сонгон шалгаруулах журмыг 2022 оны 02 дугаар сарын 14, 05 дугаар сарын 23-ны өдрүүдэд зохион байгуулж, 48 төрийн байгууллагад нийт 1.8 тэрбум төгрөгийн санхүүжилт олгоод байна. Эрүүл мэндийн сайдын тушаалаар "Иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, дадлыг бий болгох" ажлыг зохион байгуулах ажлын удирдамжийг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдөр батлуулсан. Удирдамжийн хэрэгжилтийг ханган, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах үйл ажиллагаа зохион байгуулах тухай 2/1259 тоот албан бичгийг яамд болон Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хүргүүлсэн. - Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1, 2.2.1 дэх заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл	НЭМГ-УСХЗХ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>мэндийн сайд санаачилан “Иргэдэд эрүүл идэвхтэй амьдрах, эрүүл зан үйлийг хэвшүүлэх, дадлыг бий болгох ажлыг зохион байгуулах ажлын удирдамж”-ийг батлан хэрэгжүүлж, энэ хүрээнд “Эрүүл мэндийнхээ төлөө-Алхангаа ярилцъя” аяныг улс орон даяар 2022 оны 06 дугаар сарын 04-ний Бямба гаригт зохион байгуулж, эрүүл мэндийн байгууллагууд өөрсдийн байгууллагын өртөөг байгуулан, иргэдэд эрүүл мэндийн боловсрол олгох, эрүүл мэндийг дэмжих, хамгаалах чиглэлээр хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаагаа сурталчлан, идэвхтэй оролцсон.</p> <p>- Иргэдэд идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн “ТҮМЭН” загвар дасгалыг нэвтрүүлэх, үндэсний сургагч багш бэлтгэх сургалт зохион байгуулах зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн үндэсний төв нь иргэдэд идэвхтэй хөдөлгөөн, чийрэгжүүлэлтийн “Түмэн” дасгалыг сурталчилах, үндэсний сургагч багш бэлтгэж, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх сургалтыг зохион байгуулсан (18,723,900 төгрөг, Эрүүл мэндийн дэмжих сангийн санхүүжилт). Тогтмол, үндэсний мэдлэг, энгийн, нийтээрээ (ТҮМЭН) гэсэн бүх насныханд зориулсан богино хэмжээний, загвар дасгалтай болох ажлыг эхлүүлсэн.</p> <p>- Эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих, эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх нийгмийн болон хүрээлэн буй орчны эрсдэлийг бууруулахад чиглэсэн ухуулга нөлөөллийн арга хэмжээг улсын хэмжээнд зохион байгуулах зорилгоор</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						Геронтологийн үндэсний төв нь эрүүл идэвхтэй насжилтыг дэмжих, нийгмийн болон хүрээлэн буй орчны эрүүл мэндэд сөргөөр нөлөөлөх эрсдэлийг бууруулахад чиглэсэн ухуулга нөлөөллийн арга хэмжээ-г зохион байгуулсан (50.0 сая төгрөг, Эрүүл мэндийн дэмжих сангийн санхүүжилт).		
35		4.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төслийг боловсруулж батлуулна	2021-2023		Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн А/58 дугаар тушаалаар Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах ажлын хэсэг, Төрийн нарийн бичгийн даргын 2022 оны 03 дугаар сарын 02-ны А/28 дугаар тушаалаар “Техникийн ажлын хэсгийг тус тус байгуулж, хуулийн төслийг боловсруулсан. ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн ч төсөл дэмжигдээгүй байна. Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн салбарын эрх зүйн шинэчлэлийн хүрээнд холбогдох хууль, бусад шийдвэрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн гишүүн, Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын дэд хэсгийн ахлагч, УИХ-ын гишүүн Д.Сарангэрэлийн ажлын албанд 2022 оны 07 дугаар сарын 04-ний өдрийн 1а/3191 тоот албан бичгээр хүргүүлсэн. Хууль зүй, дотоод хэргийн яамнаас ирүүлсэн Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн төсөлд санал авах тухай албан бичигт 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн	НЭМГ I-IV улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						1а/3824 тоот албан бичгээр санал хүргүүлсэн. Засгийн газрын 2022 оны 09 дүгээр сарын 22-ны өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах шийдвэр гарсны дагуу хуулийн төслийн боловсруулалтыг сайжруулах чиглэлээр холбогдох арга хэмжээг авч ажиллаж байна.		
36		5.Нийгмийн эрүүл мэндийн тогтолцоог бэхжүүлэхэд шаардлагатай дүрэм, стандартуудыг шинэчлэнэ	2021-2022		Шаардлагатай дүрэм, стандартыг шинэчлэн батлуулсан байна.	Нийгмийн эрүүл мэндийн төвийн бүтэц, үйл ажиллагааны стандартыг боловсруулсан. Уг стандартын төслийг боловсруулахад Төв аймгийн нийтийн эрүүл мэндийн төвтэй газар дээр нь очиж танилцсан. Мөн ажлын хэсгийн 4 удаагийн хурлыг зохион байгуулж, санал солилцсон.	ЭТҮГ-АЛШТХ I-IV улирал	30.0
37		6.Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулна	2020-2024		Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна.	Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсгийг Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн А/86,А/52 дугаар хамтарсан тушаалаар байгуулсан. Тамхины хяналтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг 2022 оны 06 дугаар сард Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Хууль зүй дотоод хэргийн сайдаар хамтран батлуулсан. Хууль тогтоомжийн хуулийн 20 дугаар зүйлийн дагуу яамдуудаас санал авч нэгтгэсэн. Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7, 20.8 дугаар заалтын дагуу Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх зөвшөөрөл авахаар 2022 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 1а/464 тоот албан битчгээр Сангийн яам, Хууль зүй,	БТГ-СУХ III улирал	50.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						дотоод хэргийн яаманд хүргүүлсэн. ХЗДХЯ-аас зөвшөөрөл ирүүлсэн, Сангийн яамны зөвшөөрлийг хүлээж байна.		
38		7.Нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах лавлагаа төвийн чадавхыг нэмэгдүүлж, аймаг, дүүрэг Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулна	2022-2024		3 аймаг, 2 дүүрэгт Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулсан байна.	Нийгмийн эрүүл мэндийн төв байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төсөл болон тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай Эрүүл мэндийн сайдын тушаал, холбогдох журмын төслийг боловсруулан ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн 2022 оны 09 дүгээр сарын 02-ны өдрийн хурлаар хэлэлцүүлсэн. ЭМЯ-ны Санхүү, эдийн засгийн газартай хамтран шаардлагатай эдийн засгийн тооцооллыг хийж байна.	БТГ-СУХ II-IV улирал	50.0
39	2.1.6."Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд эрүүл мэндийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, орон нутагт хийгдэх оношилгоо, эмчилгээнд алсын зайн технологи	1.Салбарын түвшинд мэдээллийн технологийн сүлжээний бүтцийг дэд бий болгоно	2021-2024	700.0 Улсын төсөв	Сүлжээний дэд бүтэцтэй байгууллага 26 болсон байна. 2021 онд 14, 2022 онд 26, нийт 40 ЭМБ	Эрүүл мэндийн салбарын "VPN" хамгаалагдсан мэдээллийн сүлжээний дэд бүтцийг Мобиком, Юнител зэрэг байгууллагуудтай хамтран Эрүүл мэндийн хөгжлийн төвд байгуулж, нийт 48 эрүүл мэндийн байгууллагыг холбосон сүлжээний дэд бүтэц бий болсон. Үүнд: 16 аймгийн нэгдсэн эмнэлэг, 9 дүүргийн эрүүл мэндийн төв, 4 дүүргийн нэгдсэн эмнэлэг, 5 Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, 6 хөдөөгийн нэгдсэн эмнэлэг, ЭМЯ-ны харьяа лавлагаа шатлалын 8 эмнэлэг болно.	БТГ-СТХ I-IV улирал	100.0
40	ашиглан, цахим эрт илрүүлэг, эргэн дуудах тогтолцоог бүрдүүлнэ.	2.Эрүүл мэндийн байгууллагад мэдээлэл солилцооны платформ нэвтрүүлнэ.	2021-2022	9,800.0 Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн байгууллагын 50 хувьд нь Мэдээлэл солилцооны платформ нэвтрэсэн байна.	Дэлхийн банкны санхүүжилтээр "Цахим Эрүүл мэнд" төслийн туслан гүйцэтгэгч "Аксис системс" ХХК-тай хамтран нийт эрүүл мэндийн байгууллагуудын тусламж, үйлчилгээнд ашиглаж байгаа програм хангамжид (хувийн эрүүл мэндийн байгууллагуудад ашигладаг Медсофт И-клиник, Вингс, Гиганет, Карте зэрэг систем) хадгалагдаж буй иргэний эрүүл мэндийн мэдээллийг нэгтгэсэн. Мөн Үндэсний дата	БТГ-СТХ III улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						төвд сервер тоног төхөөрөмжүүд байршуулан ЭМДЕГ-тай гэрээ бүхий лавлагаа шатлалын болон анхан шатны эмнэлэг, 50 гаруй хувийн эмнэлэг зэрэг эрүүл мэндийн байгууллагуудыг НIEP системд холбож, нийт эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны платформыг нэвтрүүлсэн.		
41		3.Дүрс архивлан хадгалах /PACS/ нэгдсэн тогтолцоог бүрдүүлнэ	2021-2024	5,800.0 Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн байгууллагад Дүрс архивлан хадгалах систем бүрэн ашиглагдаж эхэлсэн байна.	Дэлхийн банкны санхүүжилттэй “Цахим эрүүл мэнд” төслийн хүрээнд 7 эрүүл мэндийн байгууллага (Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Гэмтэл, согог судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Хөвсгөл, Увс, Булган аймгийн нэгдсэн эмнэлэг)-д оношилгоо, эмчилгээний дүрс архивлан хадгалах, солилцох “PACS” системийг нэвтрүүлэн ашиглаж байна.	БТГ-СТХ I-IV улирал	100.0
42		4.Орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад алсын зайн анагаах ухаан (Телемедицин) ашиглах боломжийг бүрдүүлнэ	2021-2023	500.0 Улсын төсөв	Лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 15 аймгийн зэрэглэлийн сумын эрүүл мэндийн төвд телемедицин нэвтэрсэн байна.	МН кардио програм хангамжийг ЭМЯ-ны Техникийн хороо болон Мэдээллийн технологийн зөвлөлөөр хэлэлцүүлж Ашиглах шийдвэр гарч, алсын зайн анагаах ухааны суурь системийг Улсын гуравдугаар төв эмнэлгийн зүрхний төвийн санаачлагаар лавлагаа шатлалын 4 эрүүл мэндийн байгууллага, 9 аймгийн А зэрэглэлийн 18 сумын эрүүл мэндийн төвд шинээр нэвтрүүлсэн. Уг системийг анхан болон лавлагаа шатлалын 264 эрүүл мэндийн байгууллагын 574 хэрэглэгч ашиглан телемедицинээр тусламж, үйлчилгээг үзүүлж байна. Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/129 дугаар тушаалаар “Телемедициний үндэсний сүлжээний ажиллах журам”-ыг шинэчлэн батлуулан хэрэгжүүлж байна.	БТГ-СТХ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
43		5.Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулна	2021-2024	1,200.0 Улсын төсөв (үйл ажиллагааны орлого)	Эрүүл мэндийн мэдээллийн үндэсний төв байгуулагдаж, үйл ажиллагаа нь жигдэрсэн байна.	Эрүүл мэндийн яамнаас Эрүүл мэндийн мэдээлэл, технологийн төв байгуулах үндэслэл, төсөл, бүтэц орон тоо, төсвийн төлөвлөгөө, дүрэм, Засгийн газрын тогтоолын төсөл, хуралдааны танилцуулга боловсруулж, яамдуудаас санал авч өөрөөс хамаарах бэлтгэлийг бүрэн хийсэн боловч Засгийн газрын 2021 оны 09 дүгээр сарын 15-ны өдрийн 283 дугаар тогтоолоор үндэсний хэмжээнд нэгдсэн "И-Монгол академи" улсын төсөвт үйлдвэрийн газар" байгуулахаар болсон тул ажил зогссон.	БТГ-СТХ	0
44		6.Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлнэ	2021-2022	-	Тусгай зөвшөөрлийн бүртгэлийн үйл ажиллагаа бүрэн цахимжсан байна.	Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн програмыг хөгжүүлэх, нийлүүлэх гэрээг 2022 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 142 тоот гэрээг "Аксис системс" ХХК-тай байгуулж хөгжүүлэлт бүрэн хийгдэж дууссан. 2022 оны 04 дүгээр сарын 15-ны өдрийн Мэдээллийн технологийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэгдэж эрүүл мэндийн салбарт ашиглах шийдвэрийг гаргасан. Эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл хүсэх хүсэлт, шийдвэрлэлт, олгох, сунгах зэрэг ажлууд цахимжсан. 2022 оны эхний 11 сарын байдлаар тусгай зөвшөөрөлтэй нийт 6,122 байгууллагуудын мэдээллийн шинэчлэлийг хийж мэдээллийн сан баяжуулан үйл ажиллагаандаа ашиглаж байна.	БТГ-СТХ I-IV улирал	100.0
45		8.Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвүүдэд мобайл тусламж, үйлчилгээг нэвтрүүлнэ	2021-2023	1,300.0 Улсын төсөв	Нийт 127 сум, өрхийн эрүүл мэндийн төвд мобайл тусламж, үйлчилгээ нэвтэрсэн байна.	2022 онд орон нутгийн дэмжлэгтэйгээр Улаанбаатар хотын 3 ӨЭМТ, орон нутгийн 17 СЭМТ, ДЭМБ-ын дэмжлэгтэйгээр орон нутгийн 3 СЭМТ, нийт 23 ЭМАШТҮ үзүүлэгч байгууллага "Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээнд мобайл технологийн	ЭТҮГ-АЛШТХ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						хэрэглээг өргөжүүлэх нь" арга хэмжээнд хамрагдсан. 2022 оны сүүлийн хагас жилд нийслэл, орон нутгийн 56 анхан шатны эрүүл мэндийн байгууллага мобайл технологийг өргөжүүлэх арга хэмжээнд хамрагдаж мобайл тоног төхөөрөмжийн багцыг хүлээн авсан байна. Завхан, Ховд аймгийн анхан шатны эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүдийг тоног төхөөрөмжийг хэрхэн хэрэглэх ашиглах талаар сургалтад хамруулсан. "Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх эрүүл мэндийн нэн шаардлагатай тусламж, үйлчилгээ" сэдэвт сургалт туршлага солилцох арга хэмжээг Сүхбаатар аймагт 2022 оны 04 дүгээр сарын 18-21, Баянхонгор аймагт 2022 оны 05 дугаар сарын 02-05-ны өдрүүдэд сард зохион байгуулж, нийт 142 хүн хамрагджээ. Өмнөх жилүүдэд өрх, суманд нэвтрүүлсэн мобайл тусламж, үйлчилгээ хэрэгжиж байгаа болно.		
46	2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.	1. Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн сан байгуулна	2021-2024	40,000.0 Улсын төсөв (ЭМДС)	Эрүүл мэндийн даатгалын эрсдэлийн санг даатгалын санхүүжилтийн 7 хувиар байгуулсан байна.	ЭМДҮЗ-ийн 2021 оны 08 дугаар тогтоолоор санхүүжилтийн хуваарийг, 09 дүгээр тогтоолоор "Эрсдэлийн сангийн хөрөнгийг Төрийн санд байршуулах, зарцуулах журам"-ыг, 10 дугаар тогтоолоор эрсдлийн санг 40 тэрбум төгрөгөөр буюу даатгалын санхүүжилтийн 2.8 хувиар байгуулсан байна. Коронавируст халдварын үеийн эдийн засаг, санхүүгийн хүндрэл, инфляци, валютын ханшийн өсөлттэй холбоотой Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлэх орлого буурч, төвөвлөсөн зардлыг санхүүжүүлэхэд шаардагдах төсвийн эх үүсвэр дутагдсан тул эрсдлийн сангийн хөрөнгийг зарцуулах шийдвэрийг	БТГ-СУХ III улирал	30.0 (40.0)

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						Эрүүл мэндийн үндэсний зөвлөлийн 2022 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн “Эрүүл мэндийн даатгалын 2022 оны эрсдэлийн сангийн хөрөнгийг зарцуулах тухай” 13 тогтоолоор гаргажээ.		
47	2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.	2.Төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагад Улсын төсөв (ЭМДС)-гаас амбулатори, өдрийн эмчилгээ, оношилгоонд олгох санхүүжилтийн ялгааг арилгана	2021-2024	77,400.0 Улсын төсөв (ЭМДС)	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын 75 хувьд гэрээ байгуулж, олгосон байна.	Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа 239 хувийн хэвшлийн ортой эмнэлгийн 196 буюу 82.0 хувьтай нь ЭМДЕГ-аас гэрээ байгуулан ажиллаж байна. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагыг сонгон шалгаруулах журмыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 02 дугаар тогтоолоор батлуулсан бөгөөд тус журмын дагуу сонгон шалгаруулалт зохион байгуулагдсан. Сонгон шалгаруулалтаар 196 хувийн эмнэлэг 9 нэр төрлийн 9,055 оношийн хамааралтай бүлгээр тэнцэж гэрээлсэн байна.	СЭЗГ-СДХ IV улирал	100.0
48		3. Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар гаргаж, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудаар гүйцэтгүүлэн, Улсын төсөв (ЭМД)-өөс санхүүжүүлнэ	2022-2024	3,000.0 Улсын төсөв (ЭМДС)	Урт хугацааны тусламж, үйлчилгээний 10 хувийг Улсын төсөв (ЭМД)-өөс санхүүжүүлнэ.	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдрийн “Ахмад настны урт хугацааны тусламж, үйлчилгээний загварыг турших төлөвлөгөө”-г А/127, А/333 дугаар хамтарсан тушаалаар батлуулж хэрэгжүүлэх байгууллагуудыг мэдээлэл арга зүйн удирдлагаар ханган ажиллаж байна. 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн Эрүүл мэндийн сайдын А/511 дүгээр тушаалаар “Урт хугацааны тусламж, үйлчилгээний загвар” боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг батлуулан 2 удаа мэдээлэл солилцох уулзалт, хурлыг ЭМЯ, ЭМХТ, ЭМДЕГ болон ЭМЯ-ны харьяа эрүүл мэндийн байгууллага, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбооны төлөөллийг оролцуулан зохион байгуулж загварын эхний хувилбаруудыг	БТГ-СУХ I-IV улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээн ний хувь, %
						боловсруулсан. 2022 оны 11 дүгээр сард багтаан ЭМЯ-ны Удирдлагын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.		
49		4.Эмнэлгийн хагас бие даасан байдлыг эрүүл мэндийн байгууллагуудад үе шаттай нэвтрүүлнэ	2020-2024	16,000.0 Улсын төсөв	Эмнэлгийн хагас бие даасан байдал 26 эмнэлэгт хэрэгжиж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн сайд аймаг, нийслэлийн Засаг даргатай 2022 онд байгуулсан гэрээнд аймаг, дүүргийн нэгдсэн эмнэлэгт Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байгуулах үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, ЭМЯ-тай хамтран ажиллах заалтыг тусгасан. Энэ хүрээнд ЭМЯ-аас аймаг, нийслэлийн ЗДТГ, нэгдсэн эмнэлгийн дарга, эмнэлгийн ҮЭ-ийн хороо, залуучуудын зөвлөлд ТУЗ байгуулах ажлыг хууль, журмын дагуу хамтран зохион байгуулахыг мэдэгдэж албан тоотыг 2022 оны 01 дүгээр сард хүргүүлсэн. УНТЭ, УГТЭ, АӨСҮТ-өөс гадна Өвөрхангай аймаг дахь БОЭТ, Сонгинохайрхан дүүргийн нэгдсэн эмнэлэг, Увс, Говь-Алтай, Хөвсгөл аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 5 байгууллагад ТУЗ шинээр байгуулагдан ажиллаж эхэлсэн байна. ХСҮТ, ГССҮТ, УХТЭ, Дорнод аймаг дахь БОЭТ, Архангай, Хэнтий аймгийн нэгдсэн эмнэлэг зэрэг 6 байгууллагад ТУЗ байгуулах үйл ажиллагаа дууссан болон батламжлах шатанд байна. Дундговь, Баян-Өлгий, Дархан-Уул аймгийн нэгдсэн эмнэлэг, Орхон, Өмнөговь, Ховд аймаг дахь БОЭТ-үүдэд ТУЗ зөвлөл байгуулах үйл ажиллагаанууд эхэлсэн (6 байгууллага). Баянхонгор аймгийн нэгдсэн эмнэлгийн ТУЗ-ийн олон нийтийн төлөөлөл болон эмнэлгийн хамт олны төлөөллийг сонгон	ТЗУГ I-IV улирал	70.0 (80.7)

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						шалгаруулах ажлыг аймгийн ЗДТГ-аас явуулахдаа хууль, журам, удирдамж зөрчин явуулсан тул дахин зохион байгуулах саналыг ЭМЯ-аас хүргүүлээд байна. Нийт 21 эрүүл мэндийн байгууллагад ТҮЗ байгуулагдаж, байгуулагдах шатандаа байна. Үүнээс 8 эрүүл мэндийн байгууллагад ТУЗ ажиллаж байна. Дүүргийн эрүүл мэндийн төвүүдийн бүтэц, зохион байгуулалтыг эрүүл мэндийн хуульд нийцүүлэн өөрчилж, дүүргийн нэгдсэн эмнэлэгт ТУЗ байгуулах боломж бүрдүүлэх чиглэлийг НЭМГ-т хүргүүлсэн хэдий ч дүүргийн Эрүүл мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалтыг хуульд нийцүүлэн өөрчлөх үйл ажиллагаа удаашралтай байна.		
50		5.Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлнэ	2021-2024	500.0 Улсын төсөв	Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад нэвтрүүлнэ.	Эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлж буй төрийн өмчийн 328 сумын ЭМТ, лавлагаа шатлалын 64 эмнэлгийн байгууллагад гүйцэтгэлд суурилсан санхүүжилт нэвтэрсэн. ЭМДҮЗ-ийн 2021 оны 03 дугаар тогтоолын хэрэгжилт, үр дүнг үнэлж, үнэ тарифын өсөлт, цалингийн доод жишиг шинэчлэхтэй холбоотойгоор уг журмыг дахин шинэчлэн боловсруулж, ЭМДҮЗ-ийн 2022 оны 01 дүгээр тогтоолоор батлуулсан. 562 оношийн хамааралтай бүлгийг 705 болгож, амбулаторийн тусламж, үйлчилгээ, өдрийн мэс засал, ажилбар, эмчилгээг даатгалаас санхүүжүүлэхээр жагсаалтыг өргөжүүлсэн. Мөн ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоолоор баталсан “Анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын санхүүжилтийн журам”-ын хэрэгжилт, үр дүнг үнэлж, журмыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн	СЭЗГ-СДХ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						2022 оны 05 дугаар тогтоолоор батлуулж анхан болон лавлагаа шатлалын тусламж, үйлчилгээний санхүүжилтийн уялдаа холбоог хангасан байна.		
51		6.Санхүүжилтийн гүйцэтгэл, удирдлагын хагас бие даасан байдалтай уялдуулан эрүүл мэндийн байгууллагуудын хөгжлийн төлөвлөлтийг хэрэгжүүлнэ	2021-2024		Төлөвлөгөөг хэрэгжүүлж эхэлсэн байна.	Эрүүл мэндийн байгууллагын стратеги төлөвлөгөөнд гүйцэтгэлийн санхүүжилтийн талаар хэрэгжүүлэх үйл ажиллагааг тусгах чиглэлийг 2022 оны 4/181 албан тоотой төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, БОЭТ-д хүргүүлсэн. НЭМҮТ, ЭНЭҮТ-2, ЦССҮТ, ЗӨСҮТ, ГҮТ, ГССҮТ, ХСҮТ, ХӨСҮТ зэрэг байгууллагуудын стратеги төлөвлөгөөний төслийг тус бүр 3-4 удаа хянан санал өгч, засварууд хийгдэж стратеги төлөвлөгөөг эцэслэх шатанд байна.	БТГ-СУХ, ТЗУГ I-IV улирал	70.0
52		7.Эрүүл мэндийн үндэсний тооцоо болон тусламж, үйлчилгээний тариф тогтооход ашиглах зорилгоор тусламж, үйлчилгээний өртгийн бүртгэлийн цахим тогтолцоог эрүүл мэндийн байгууллагуудад нэвтрүүлнэ	2021-2024	600.0 Улсын төсөв (ЭМДС)	Эрүүл мэндийн байгууллагын 20 хувьд цахим бүртгэлийн тогтолцоо нэвтэрсэн байна.	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газартай гэрээ бүхий 828 гаруй эрүүл мэндийн байгууллагад тусламж, үйлчилгээний цахим тогтолцоо нэвтрүүлсэн. Олон улсын "Эрүүл мэндийн үндэсний тооцооны систем-2011" аргачлалын дагуу үндсэн 9 ангиллаар тооцооллыг гаргаж байна. Энэхүү ангиллаар санхүүгийн тайланг нэгтгэн тайлагнах үйл ажиллагааг сайжруулах зорилгоор Эрүүл мэндийн хөгжлийн төвтэй хамтарсан 7 удаагийн уулзалт хурлыг зохион байгуулсан. Тайлангууд нэгтгэгдэж байна.	БТГ-СУХ IV улирал	90.0
53	2.1.7. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн оновчтой арга, хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл	8.ЭМДЕГ-ын бүтцийг оновчтой болгож, хүний нөөцийг чадавхижуулна	2021-2024		ЭМДЕГ-ын хүний нөөцийг тогтмол чадавхжуулна.	ЭМДЕГ нь 2022 онд албан хаагчдын чадавхи бэхжүүлэх 15 удаагийн сургалт зохион байгуулж, давхардсан тоогоор 492 албан хаагч хамрагдсан. Түүнчлэн Удирдлагын академиас зохион байгуулж буй мэргэшүүлэх багц цагийн сургалтад 26	БТГ-СУХ IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний нэр, төрлийг нэмэгдүүлж, эрсдэлийн сан байгуулна.					төрийн албан хаагчид хамрагдсан байна. Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, үнэлгээ “Алсын хараа-2050” сэдэвт богино хугацааны зайн сургалтад 3 албан хаагч, “Төрийн албаны хүний нөөцийн удирдлага ба сургалтын тогтолцоо” сэдэвт сургалтад 2 албан хаагч, “Үр ашгийн болон эрсдэлийн шинжилгээ, их өгөгдлийг бодлогын шийдвэрт ашиглах” сэдэвт сургалтад 2 албан хаагч тус тус хамрагдсан байна. “Алсын хараа-2050, Шинэ сэргэлтийн бодлого” сургалтад ЭМДЕГ-ын удирдлага, нийт 10 хүн оролцжээ. “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах хөрөнгө оруулалтын хөтөлбөр” төслийн багтай хамтран 7 сэдвийн хүрээнд тус агентлагийн Бодлого төлөвлөлтийн газар, Худалдан авалт гэрээлэлтийн газар, Тусламж, үйлчилгээний чанар, төлбөрийн хяналтын газрын нийт 80 албан хаагчдад сургалт зохион байгуулсан байна.		
54		10.Эрүүл мэндийн даатгалыг цахимжуулна	2021-2024	300.0 Улсын төсөв (ЭМДС), Гадаадын зээл, тусламж	Эрүүл мэндийн даатгалын цахим тогтолцоог бий болгож, бүх шатны эрүүл мэндийн байгууллагыг холбоно.	Үндэсний дата төвд сервер тоног төхөөрөмжүүдийг байршуулан ЭМДЕГ-тай гэрээ бүхий лавлагаа шатлалын болон анхан шатны эмнэлэг, 50 гаруй хувийн эмнэлэг зэрэг эрүүл мэндийн байгууллагуудыг HIEP Health.gov.mn цахим системд холбож, нийт эрүүл мэндийн салбарын мэдээлэл солилцооны платформыг нэвтрүүлсэн.	БТГ-СТХ I-II улирал	100.0
55		11.Төрөөс хариуцах иргэдийн шимтгэл, албан бус салбарын даатгуулагчдын	2021-2024	60,212.5 Улсын төсөв (ЭМДС)	ЭМД-ын тухай хуулийн 6.1.2, 6.1.3, 6.1.5, 6.1.9, 6.1.12-д заасан даатгуулагчийн	Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1-д “Энэ хуулийн 6.1-д заасан даатгуулагчийн эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн хувь хэмжээг Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн	БТГ-СУХ IV улирал	50.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
		хамрагдалт, шимтгэлийн хэмжээг өсгөх замаар Улсын төсөв (ЭМДС)-гийн орлогыг нэмэгдүүлнэ			шимтгэлийн хувь, хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2-оос доошгүй хувиар, 6.1.4-т заасан даатгуулагчийн шимтгэлийн хувь, хэмжээг нэг сарын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 4-өөс доошгүй хувиар тус тус тогтооно.	Засгийн газар жил бүр тогтооно" гэж заасны дагуу Засгийн газрын 2021 оны 408 дугаар тогтоолоор эрүүл мэндийн даатгалын 2022 оны шимтгэлийн хувь, хэмжээг хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн, малчин, 0-18 насны хүүхэд, оюутан, суралцагчдад ХХДХ-ийн 1 хувь, гадаадын иргэн, харьяалалгүй хүнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний 2 хувь байхаар тогтоосон байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн орлого нийт 474.7 тэрбум төвлөрүүлэхээс 296.1 тэрбум төгрөг төвлөрүүлж 62.4 хувьтай, шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчийн шимтгэлийн орлого 22.9 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 18.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 79.9 хувьтай, төр даатгалыг нь хариуцах иргэдийн шимтгэлийн орлого 109.1 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 109.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 100 хувьтай, төр төлбөрийг нь хариуцах эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг эрүүл мэндийн даатгалын байгууллагаар дамжуулан санхүүжүүлэхэд улсын төсвөөс олгох хөрөнгө 360.2 тэрбум төгрөг төвлөрүүлэхээс 495.3 тэрбум төгрөгийг төвлөрүүлж 100 хувьтай, бусад орлого 2.9 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн байна. 2022 оны 3 дугаар улирлын байдлаар хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийн хамралт 87%, малчдын хамралт 44.3%, их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн суралцагчдын хамралт 31.2% байна.		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээн ний хувь, %
56		12.Олон улсын эмнэл зүйн удирдамжийн цахим санг нэвтрүүлнэ	2021-2024	1,400.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Олон улсын эмнэл зүйн удирдамжийн нэвтрүүлсэн байна.	Эрүүл мэндийн салбарт UpToDate олон улсын цахим платформыг нэвтрүүлэн цахим платформыг хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор эмнэлгийн мэргэжилтний тасралтгүй сургалтын багц цагийн 1/3-ийг платформоос бүрдүүлэх боломжтой болсон. Мөн платформыг сурталчлах, эмнэлгийн мэргэжилтнүүдэд зориулсан платформын талаарх сургалтыг тогтмол хийж байна. 2022 оны 10 дугаар сарын байдлаар нийт 44,009 хэрэглэгч платформыг ашиглаж байгаа нь сар бүр платформ хэрэглэгчдийн тоо тогтмол нэмэгдэж байгаа үзүүлэлттэй байна (2022 оны 08 дугаар сар 25,254, 09 дүгээр сар 36,209 хэрэглэгч).	ЭТҮГ-АЛШТХ, ЭМДЕГ I улирал	100.0
57	2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	1.Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтын нэвтрүүлнэ	2021-2024		Эмийн аюулгүй байдлын цахим бүртгэл хяналтыг эм ханган нийлүүлэх байгууллага 100 хувь хамрагдсан байна.	Лайсмед программд нэвтэрч эмийн аюулгүй байдлын тайлан илгээх боломжтой 384 эм ханган нийлүүлэх, үйлдвэрлэх байгууллагыг цахимжуулах ажил бүрэн хийгдсэн байна. Тус хугацаанд 89 эмийн аюулгүй байдлын тайланг Эм судлалын салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, шийдвэрлэсэн. Тус тайлангуудад эмийн аюулгүй байдал зөрчигдөөгүй, өөрчлөлт ороогүй байна.	БТГ-СТХ I-IV улирал	100.0
58		2.Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийнэ	2022-2023		Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалтын эрхзүйн орчин хэрэгжсэн байна.	Эм, эмнэлгийн хэрэглэгдэхүүний тухай хуулийн төсөлд зайлшгүй шаардлагатай эмийн үнийн зохицуулалт хийх заалт тусгаж байгаа. Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 05 дугаар сарын 11-ний өдрийн 28 дугаар хуралдааны тэмдэглэлээр хуулийн төслийг эргүүлэн татсан тул Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/330 дугаар тушаалаар эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг	БТГ-СУХ III улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						дахин боловсруулах ажлын хэсэг байгуулан ажиллаж байна. Ажлын хэсгийн зүгээс хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж дууссан, үзэл баримтлалын төслийг Хууль зүй, дотоод хэргийн сайд, Эрүүл мэндийн сайд, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдаар батлуулахаар ажиллаж байна.		
59		3.Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ боловсруулж, хэрэгжүүлнэ	2022-2024	500.0 Улсын төсөв	Эмийн чанар, аюулгүй байдлыг хангах арга хэмжээ Засгийн газрын тогтоолоор батлагдсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/450 дугаар тушаалаар “Эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн чанар, аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөө”-г 2022-2025 онд хэрэгжүүлэхээр баталсан байна.	БТГ-СУХ II-III улирал	90.0
60		4.Нянгийн тэсвэржилтийн хяналтын дэлхийн сүлжээнд нэгдэж, нянгийн эсрэг эмийн зохистой хэрэглээг хянах тогтолцоог бүрдүүлнэ	2021-2024	500.0 Гадаадын зээл, тусламж	21 аймгийн нэгдсэн эмнэлгүүд сүлжээнд нэгдэж, нянгийн тэсвэржилтийн талаарх мэдээллээ өгч хэвшсэн байна.	Нянгийн тэсвэржилтийн сүлжээнд нэгдэх бэлтгэл ажлыг хангаж, нянгийн тэсвэржилтийн WHO.NET программ дээр ажиллаж сургах сургалтад 21 аймгийн эмч, мэргэжилтнүүдийг хамруулах хөтөлбөр, төлөвлөгөөг Халдварт өвчин судлалын үндэсний төвийн Нян судлалын лабораторитой хамтран боловсруулж байна. ДЭМБ-ын Номхон далайн Баруун бүсийн Нянгийн тэсвэржилтийн тандалтын асуудал хариуцсан мэргэжилтэн манай улсад 2022 оны 10 дугаар сарын 10-14 ний хооронд ажиллаж 2022 оны 10 сарын 13-ны өдөр “Нянгийн тэсвэржилтийн тандалт, тэсвэржсэн нянгийн мэдээллийг боловсруулах нь” сургалтыг зохион байгуулж, сургалтад нийт 40 хүн хамрагдсанаас цахимаар 21 аймгийн лабораторийн 25 хүн оролцжээ. WHONET-ийн тухай ойлголт, хэрэглээ, дүгнэлт гаргах аргачлал, шинэчлэлийн талаар олон улсын зөвлөх дэлгэрэнгүй мэдээлэл өгч, манай	ЭТҮГ-ЭТЧАБХ I-IV улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						улсад WHONET програмыг хэрхэн ашиглаж байгаа болон Монгол Улс тэсвэржсэн нянгийн мэдээллийг ДЭМБ-ын "GLASS" системд хүргүүлдэг болох талаар мэдээллийг түгээсэн байна.		
61	2.1.8.Эм, эмнэлгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдлыг хангаж, хүртээмжийг нэмэгдүүлэн бүртгэл, хяналтын цахим тогтолцоог бүрдүүлнэ.	5.Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллага байгуулна.	2021-2024	Улсын төсөв	Эмийн зохицуулалтын төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа жигдэрсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 222 дугаар тогтоолоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тооны дээд хязгаарыг 80 байхаар баталсан. ЭЭХХЗГ нь 7 газар (Лиценз, зөвшөөрлийн зохицуулалтын газар, Эмийн аюулгүй байдлын тандалт, судалгааны газар, Чанарын хяналтын газар, Эм шинжлэх лаборатори, Захиргаа, удирдлагын газар, Эм хангамжийн газар, Эмнэлгийн тоног төхөөрөмжийн газар) болон Эмийн бүртгэлийн болон Эм үйлдвэрлэлийн хэлтэстэй үйл ажиллагаагаа явуулж байна. Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 378 дугаар тогтоолоор Мэргэжлийн хяналтын төв болон орон нутгийн байгууллагын 28, Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторийн Эмийн хяналтын лабораторийн 24, нийт 52 албан хаагчийг Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газарт орон тоо, цалингийн сан, холбогдох зардлын хамт 2021 оноор тасалбар болгон шилжүүлэх арга хэмжээ авахыг Шадар сайд, Эрүүл мэндийн сайд, Сангийн сайд нарт даалгасны дагуу Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газрын орон тоог 132 болгон	ТЗУГ	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээн ний хувь, %
						нэмэгдүүлсэн. Засгийн газрын 222 дугаар тогтоолын дагуу байгуулагдсан Эм, эмнэлгийн хэрэгслийн хяналт, зохицуулалтын газар нь үйл ажиллагаагаа хэвийн явуулж байгаа болно.		
62		6.Төр хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд тэргүүлэх чиглэлийг үндэслэн эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийг бодлогоор дэмжинэ	2021-2024		Эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэлийн дотоодын зах зээлд эзлэх хувь 2 болсон байна.	2022 оны 10 дугаар сарын байдлаар эмнэлгийн хэрэгслийн 83 хувийг импортлож, 17 хувийг дотоодод үйлдвэрлэсэн байна. ЭМЯ-наас 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр дотоодын үйлдвэрүүдтэй холбоотой тулгамдаж буй асуудлаар ЭЭХХЗГ, ЗӨСҮТ, НЭМҮТөвийн дарга, удирдлагуудтай уулзалт хийж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлж байна. Үүнд: ЭЭХХЗГгазраас эмийн-10, БИБ-7, уламжлалт эмийн-5, биобэлдмэлийн-1, нийт 23 үйлдвэрт үнэлгээ хийсэн. Үйлдвэрүүдийн зүгээс түүхий эдийн үнийн өсөлт, тээвэрлэлтийн зардал өссөн зэргээс хамаарч санхүүжилт хүндрэлтэй байгаа тул татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх хүсэлт гаргасан. Дотоодын үйлдвэр ханган нийлүүлэх байгууллагыг дэмжих үүднээс "Эрүүл мэндийн технологи-2022" үзэсгэлэнг 2022 оны 10 дугаар сарын 07-09-ны өдөр зохион байгуулж, тоног төхөөрөмж ханган нийлүүлэгч 14, Эм, эмнэлгийн хэрэгсэл ханган нийлүүлэх 41, БНСУ-аас 11 аж ахуйн нэгж оролцсон. Үүнээс эм, эмнэлгийн хэрэгслийн 5 үйлдвэр оролцож, өөрсдийн бүтээгдэхүүнээ танилцуулж, борлуулалт хийсэн байна.	БТГ-СУХ IV улирал	100.0
63		7.Биобэлдмэлийн үйлдвэрлэлийг эрчимжүүлнэ	2021-2024	1,500.0 Улсын төсөв	Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэл 25 хувиар өссөн байна.	НЭМҮТөвд 24 төрлийн тэжээлт орчин үйлдвэрлэлд нэвтрүүлсэн. Чанарын хяналтын лабораторид хэрэглэгдэх 10 гаруй нэр төрлийн тэжээлт орчныг захиалгын дагуу бэлтгэсэн. ЗӨСҮТөв нь үндсэн	БТГ-СУХ IV улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						тэжээлт орчин-600 литр, ялган оношлох-290 литр, нян залгиур-300 литр, будаг, урвалж уусмал-550 литр зэрэг тэжээлт орчин үйлдвэрлээд байна. ЭМЯ-наас 2022 оны 09 дүгээр сарын 28-ны өдөр Биобэлдмэл, тэжээлт орчны үйлдвэрлэлийг эрчимжүүлэх асуудлаар ЭЭХХЗГ, ЗӨСҮТ, НЭМҮТөвийн дарга, холбогдох мэргэжилтнүүдтэй уулзалт зохион байгуулж, шаардлагатай санхүүжилтийн тооцоолол хийсэн (313 сая төгрөгийн санхүүжилт шаардлагатай тооцоолол гарсан).		
64		9.Эмнэлгийн тоног төхөөрөмжийн чанар аюулгүй байдал, бүртгэл, засвар үйлчилгээний тогтолцоог бэхжүүлнэ	2021-2024	1,000.0 Улсын төсөв	Эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний явуулын лаборатори байгуулсан байна.	Бүгд Найрамдах Польш Улсын Засгийн газар, Монгол Улсын Засгийн Газар хооронд байгуулсан нөхцөлт зээлийн хэлэлцээрийн хүрээнд Польш Улсын Storalczyk Mirosław Technologia Pozarnicza компанитай МОН/2021-005-0723 дугаартай гэрээ байгуулсан. Уг гэрээний дагуу 2 ширхэг эмнэлгийн тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээний автомашин (явуулын лаборатори) нийлүүлэгдэнэ. Гэрээний дагуу 2022 оны 06 дугаар сараас эхлэн автомашины нийлүүлэлт эхлэхээр байсан боловч Украин Улсад болж буй дайны улмаас тээврийн хэрэгслийн үйлдвэрлэлийн эд ангиудын нийлүүлэлт тасалдаж, гэрээний нийлүүлэлтийн хугацаа хойшилсон. 2022 оны 12 дугаар сарын дундуур тээвэрлэлт хийгдэж эхлэх талаар гүйцэтгэгч байгууллагаас мэдээлэл ирүүлжээ.	БТГ-СУХ IV улирал	50.0
65	2.1.9. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн	1.Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтын сүлжээг Бүсийн оношилгоо,	2021-2024	250.0 Улсын төсөв	3 БОЭТ төгсөлтийн дараах сургалт явуулдаг болно.	Өвөрхангай, Өмнөговь, Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд сургалт эрхлэх зөвшөөрлийг Эмнэлгийн мэргэжилтний хөгжлийн зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 30-ны өдрийн	ТЗУГ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	Чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	эмчилгээний төвд бий болгон, чадавх бэхжүүлнэ				хурлын 5, 6, 7 дугаар тогтоолоор олгосон. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад Өвөрхангай 3, Өмнөговь 1, Ховд 2 резидент, нийт 6 эмч элсүүлэн сургаж байна. Өмнөх онд сургалт эрхлэх зөвшөөрөл авсан Орхон 3, Дорнод 3, нийт 6 эмчийг элсүүлэн сургаж байна. 2022-2023 оны хичээлийн жилд Ерөнхий мэргэшил судлал үндсэн мэргэшлийн төгсөлтийн дараах сургалтад сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий 5 Бүсийн оношилгоо, эмчилгээний төвд нийт 12 резидент эмчийг сургаж байна.		
66		2.Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацын тэргүүлэх чиглэлээр эмнэлгийн мэргэжилтэнг гадаадад урт хугацааны сургалтад хамруулна	2020-2024	706.0 Улсын төсөв	Эмнэлзүйн чиглэлээр 15 эмнэлгийн мэргэжилтэнг гадаад улсад урт хугацаагаар суралцуулсан байна.	Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаалаар “Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл”-ийг баталсан. Тэргүүлэх чиглэлийн дагуу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, амаржих газраас 2022-2026 онд гадаад улсад урт, богино хугацаанд эмнэлгийн мэргэжилтнийг суралцуулах сургалтын захиалгыг авсан. Улсын гуравдугаар төв эмнэлгээс Япон Улсад Уушиг судлал чиглэлээр 1, БНСУ-д Мэдрэл судлал чиглэлээр 1 эмч, нийт 2 эмч гадаад улсад суралцаж байна.	ТЗУГ I-IV улирал	30.0
67		3.Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээг хэрэгжүүлнэ	2021-2024	1,000.0 Улсын төсөв	100 хүртэлх эмч, мэргэжилтэн ажиллан суралцсан байна.	Эмнэлгийн мэргэжилтний ажиллан суралцах арга хэмжээний хүрээнд 2022 оны эхний 11 сарын байдлаар нийт 271 эмчийг ажлыг байранд сургасан байна. Үүнд: 1. Бөөр, шээсний замын дурангийн мэс засал судлалын мэргэжил дээшлүүлэх 1 сарын сургалтад 15 аймгийн бөөрний мэс	ТЗУГ I-IV улирал	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээн ний хувь, %
						<p>заслын 15 эмч, 15 сувилагч (14 хоног ажлын байранд),</p> <p>2. Ангиографийн тоног төхөөрөмж, компьютер томографийн аппаратаар хангагдсан 5 аймгийн 6 эмчийг УГТЭ-т ангиограф/судсан дотуурхи эмчилгээ, оношилгоо судлалын 1 жилийн сургалтад 2022 оны 01 сард элсүүлэн суралцуулж байна. Сургалтын сүүлийн 2 сарын хугацаанд эдгээр эмч нарыг ажлын байранд нь сургах хөтөлбөртэй.</p> <p>3. УГТЭ-ийн Харвалт шигдээсийн баг нь Орхон аймгийн БОЭТ, Булган аймгийн нэгдсэн эмнэлэгт сургалт зохион байгуулж, 14 эмч хамрагдсан. Орхон аймгийн БОЭТ, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн 14 эмч УГТЭ-т зүрх судлалын сургалтад 9 сард хамрагдсан.</p> <p>5. Монголын Хэт авиан оношилгооны нийгэмлэгтэй хамтран хэвлийн хөндийн хэт авиан оношилгооны 3 сарын мэргэжил дээшлүүлэх сургалтыг ажиллан суралцах хөтөлбөрөөр орон нутагт 2 удаа зохион байгуулж, Хөвсгөл аймгийн 28 сумын ЭМТ-ийн 30 эмч, Өвөрхангай аймгийн сум, өрхийн 30 эмч, нийт анхан шатны 60 эмчийг сургасан байна.</p> <p>6. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэг, оношилгооны хэвлийн болон бамбайн хэт авиа, дурангийн оношилгоо хийх эмч нарт зориулсан онолын сургалтыг цахимаар зохион байгуулж, дүрс оношилгооны 55 эмч, дурангийн 78 эмч хамрагджээ.</p> <p>8. Аймаг, нийслэлийн дүрс оношилгооны эмч нарын дадлага сургалтыг УНТЭ-ийн Эрүүл мэндийг дэмжих төвд, дурангийн дадлага сургалтыг Интермед, Монгол-Япон</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						эмнэлэг, Сонгдо болон Орхон аймгийн Медипас эмнэлэгт тус тус зохион байгуулсан. Энэхүү сургалтад Сүхбаатар, Говьсүмбэр, Архангай, Өмнөговь, Ховд, Булган, Дорнод зэрэг 7 аймаг, 9 дүүргийн 28 дурангийн эмч, сувилагч хамрагдсан байна.		
68		4.Эрүүл мэндийн байгууллага цалин, урамшууллыг ёс зүй, харилцаа хандлагатай уялдуулж олгодог болсон байна.	2022-2024			Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын нийгмийн баталгааг хангах, эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээг нэмэгдүүлэх, эрүүл мэндийн байгууллагуудын өрсөлдөх чадварыг сайжруулах, эмнэлгийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэх зорилгоор “Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагчийн албан тушаалын цалингийн доод хэмжээ, сүлжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоол батлагдан хэрэгжиж эхлээд байна.	БТГ-СУХ III улирал	70.0
69	2.1.9. Эрүүл мэндийн ажилтны эрх зүйн шинэчлэл хийж, хүний нөөцийн чадавхыг нэмэгдүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ.	5.Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөр хэрэгжүүлнэ	2021-2023	933.0 Улсын төсөв	Хөтөлбөрийн үйл ажиллагаа хэрэгжилт 70 хувь байна.	Эрүүл мэндийн ажилтны нийгмийн хамгааллын хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд жил болгоны 08 дугаар сарыг Эрүүл мэндийн ажилчдын нийгмийн хамгааллыг дэмжих сар болгодог. Засгийн газрын 2022 оны 107 дугаар тогтоолоор эрүүл мэндийн ажилчдын цалингийн доод жишгийг шинэчлэн тогтоож, эрүүл мэндийн байгууллагууд эмч, ажилчдын цалинг нэмэгдүүлсэн байна. Тухайлбал, Өвөрхангай аймгийн Хархорин сум нь эмч, ажилчдын үндсэн цалинг 10-25 хувиар нэмэгдүүлж, улирал бүр урамшуулал, Хавдар судлалын үндэсний төв эмч, ажилчдынхаа үндсэн цалинг 43 хүртэл хувиар нэмэгдүүлэхээс гадна 15 хүртэлх сая төгрөгийн урамшуулал, Гэмтэл, согог судлалын үндэсний төв эмч, эмнэлгийн	БТГ-СУХ I-IV улирал	70.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						ажилчиддаа 500.000 төгрөгийн урамшуулал олгож, сувилагч нарын үндсэн цалинг 10-25 хувиар нэмсэн, Баянгол дүүргийн эрүүл мэндийн төв 2021 онд нийт ажилчдынхаа цалинг 30 хувь нэмэгдүүлсэн бол 2022 онд гүйцэтгэлтэй нь уялдуулан 20 хувь нэмэгдүүлсэн байна. Амгалан амаржих газар 2022 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс эмч эмнэлгийн ажилчдын цалингаа 10-20 хувиар нэмсэн байна. УНТЭ гүйцэтгэлийн санхүүжилтийн үр дүнд 2022 онд 33 эмч, ажилтандаа орон сууцны урьдчилгаа болох тус бүр 30 сая хүртэлх төгрөг олгосон, УГТЭ нийт ажилчидынхаа үндсэн цалинг 40 хувиар нэмэгдүүлжээ. Эмч, ажилчдынхаа үндсэн цалинг нэмэхийн зэрэгцээ орон сууцны асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж байна. Тухайлбал, Сонгинохайрхан дүүргийн ЭМТ-ийн 17 ажилтанд орон сууцны урьдчилгаа төлбөрийн дэмжлэг үзүүлэхэд 30.0 сая төгрөг, 20 ажилтанд орон сууцны зээлийн хөнгөлөлтөд 20.0 сая төгрөг, 11 ажилтанд монгол гэр тус бүр олгосон байна.		
70		6.Сувилахуйн мэргэжилтний төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төсөл хэрэгжүүлнэ	2021-2024	500.0 Гадаадын зээл, тусламж	Сургалтыг удирдах сувилагч-сургагч багш 50-аас доошгүй бэлтгэгдсэн байна. Сургалтын 2-3 хөтөлбөр шинэчлэгдсэн байна.	Япон Улсын ЖАЙКА хамтын ажиллагааны байгууллагын “Эмч ба сувилагчийн төгсөлтийн дараах сургалтыг сайжруулах төслийн хүрээнд Сувилахуйн сургагч багш бэлтгэх 3 хоногийн сургалтыг 2 удаа зохион байгуулж, сургалтад сувилахуйн төгсөлтийн дараах сургалт эрхлэх зөвшөөрөл бүхий төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв, Орхон аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төв, Дархан-Уул, Булган аймгийн нэгдсэн эмнэлгийн сувилагч нар хамрагдаж,	ТЗУГ I-IV улирал	70.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>төгсөлтийн дараах сургалт сувилахуйн мэргэшүүлэх сургалт удирдах багшаар бэлтгэгдсэн. Түүнчлэн “Сувилахуй, эх барихуйн төгсөлтийн дараах сургалтын чадавхыг сайжруулах сургалт”-д ЭМЯ, ЭМХТ, УХТЭ, Орхон аймгийн БОЭТ, ЭХЭМҮТ, ЭНЭҮТ-2, Өргөө, Хүрээ амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн нийт 17 сувилагч, эх баригч нарыг 2 ээлжийн сургалтад хамруулсан байна.</p> <p>Сувилагчийн төгсөлтийн дараах мэргэшүүлэх сургалтын 31 чиглэлээр сургалтын хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн А/774 дүгээр тушаалаар байгуулагдсан. Боловсруулсан сургалтын хөтөлбөрийн 4 дугаар улиралд багтаан Эрүүл мэндийн хөгжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж баталгаажуулахаар ажиллаж байна.</p>		
71		7.Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2021-2024 оны чиглэлийг батлан хэрэгжүүлнэ	2021-2024	600.0 Гадаадын зээл, тусламж	100-аас доошгүй эмнэлгийн мэргэжилтэн богино хугацааны гадаад сургалтад хамрагдсан байна.	<p>“Төгсөлтийн дараах гадаад сургалтын 2022-2025 оны тэргүүлэх чиглэл батлах тухай” Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/185 дугаар тушаал батлуулсан. Тэргүүлэх чиглэлийн дагуу төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, тусгай мэргэжлийн төв болон аймаг, нийслэлийн нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн төв, амаржих газраас 2022-2026 онд гадаад улсад урт, богино хугацаанд эмнэлгийн мэргэжилтнийг суралцуулах сургалтын захиалгыг авсан.</p> <p>ЭХЭМҮТ-ийн 8 эмч 2022 оны 07 дугаар сард хүүхдийн яаралтай тусламжийн чиглэлээр ОХУ-д; УНТЭ-ээс Турк Улсад Алло-үүдэл эс шилжүүлэн суулгах</p>	БТГ-СУХ I-IV улирал	30.0 (32.0)

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>эмчилгээ чиглэлээр 6 эмнэлгийн мэргэжилтэн 30 хоногийн хугацаагаар 2 удаагийн ээлжээр; АНУ-д Цусны болон бусад хавдрын молекул генетик, цитогенетик чиглэлээр 2 эмнэлгийн мэргэжилтэн 18 хоногийн хугацаагаар; Тайвань Улсад Гуурсан хоолойн хэт авиан уян дуран чиглэлээр 3 эмнэлгийн мэргэжилтэн 16 хоногийн хугацаагаар; УХТЭ-ээс БНСУ-д Зүрхний хавхлага солих судсан дотуурх мэс засал чиглэлээр 3 эмнэлгийн мэргэжилтэн 60 хоногийн хугацаагаар; УГТЭ-ээс Турк Улсад Алло-үүдэл эс шилжүүлэн суулгах эмчилгээ чиглэлээр 2 эмнэлгийн мэргэжилтэн 15 хоногийн хугацаагаар; БНСУ-д Зүрхний том судасны гаж байрлал засах мэс засал чиглэлээр 2 эмнэлгийн мэргэжилтэн 14 хоногийн хугацаагаар; Хавдар судлалын үндэсний төвөөс БНСУ-д Хорт хавдрын хими эмчилгээ чиглэлээр 2 эмнэлгийн мэргэжилтэн 14 хоногийн хугацаагаар; Өргөө амаржих газар төрөлжсөн мэргэшлийн эмнэлгээс Тайвань Улсад Дутуу нярайн өвчин эмгэгийн оношилгоо, эмчилгээ чиглэлээр, Инвазив бус пренатал тест чиглэлээр 4 эмнэлгийн мэргэжилтэн 30 хоногийн хугацаагаар тус тус суралцсан.</p> <p>Анагаахын шинжлэх ухаан, технологийн дэвшил, инновацийн 2 чиглэлээр 9 эмнэлгийн мэргэжилтэн, төгсөлтийн дараах мэргэжил дээшлүүлэх сургалтын 7 чиглэлээр 23 эмнэлгийн мэргэжилтэн тус тус суралцсан бөгөөд нийт 32 эмнэлгийн мэргэжилтэн 14-60 хоногийн хугацаагаар суралцсан байна.</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
72	2.1.10. Үйлчлүүлэгч, эмчлүүлэгчийн эрүүл мэндийн эрхийг хамгаалах хууль, эрх зүйн орчныг бүрдүүлнэ.	1.Эрүүл мэндийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж, батлуулна	2021-2022		Хуулийн төслийг УИХ-аар хэлэлцүүлж, батлуулсан байна.	Эрүүл мэндийн салбарын санхүүжилтийн шинэчлэл, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгох ажлын хүрээнд Эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн үзэл баримтлал, хуулийн төсөл, танилцуулга, хуулийн зарим зохицуулалтын хэрэгжилтэд хийсэн үр дагаварын үнэлгээ, хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг боловсруулан бүх яамдаас санал авч холбогдох саналыг тусган эцэслэсэн. Хуулийн төслүүдийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхээр Эрүүл мэндийн сайдын 2022 оны 05 дугаар сарын 12-ны “Хүсэлт хүргүүлэх тухай” 1а/2282 тоот албан бичгээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлсэн.	БТГ-СУХ IV улирал	30.0
73	2.1.11. Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг шаттайгаар байгуулна.	1.Барилга байгууламжийг барьж, тоног төхөөрөмжөөр хангах, хүний нөөцийг бүрдүүлнэ	2021-2024	3,000.0 Улсын төсөв	Бүсийн эмнэлэг, оношилгооны төвийг шаттайгаар байгуулна.	Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар Дорнод аймгийн БОЭТ-ийн барилга нь 11.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй батлагдсан бөгөөд худалдан авах ажиллагаа зохион байгуулагдаж “Ихбазар констракшн” ХХК-тай гэрээ байгуулж барилга угсралтын ажил 36 хувьтай байна. Мөн БОЭТ-ийн ачааллыг бууруулах зорилгоор Өвөрхангай аймгийн Хархорин суманд 100 ортой нэгдсэн эмнэлгийн барилгыг 2022 оны төсвийн тухай хуульд тусгагдсан бөгөөд худалдан авах ажиллагааг зохион байгуулж “Би энд Би констракшн” ХХК-тай гэрээ байгуулсан бөгөөд барилга угсралтын ажил 20	СЭЗГ-ХОХ I-IV улирал	50.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						хувьтай байна. Тус эмнэлэг ашиглалтад орсноор Төвийн бүсийн БОЭТ-ийн ачаалал багасч, Хархорин сумын ойролцоох 3 аймгийн 10 сумын иргэдэд үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээ сайжрах тооцоололтой байна.		
74		2.Ховд аймгийн Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл барина.	2022-2024	5,137.5 Гадаадын зээл, тусламж	Барилгын өргөтгөлийн ажлын гүйцэтгэл 30 хувь байна.	Азийн хөгжлийн банкны хөнгөлөлттэй зээл “Эмзэг бүлгийн хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд хийгдэнэ. Уг төсөл нь 3 үе шаттай бөгөөд I үе шатын хүрээнд “Баруун бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн барилгын өргөтгөл”-ийн зургийн зөвлөх компани “Татах хүч” ХХК шалгарч 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Ажлын явц 40 хувьтай байна. Түүнчлэн 2022 онд Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын өргөтгөлийн зураг төсөв хийхээр “Татах хүч” ХХК-тай 2022 оны 08 дугаар сарын 25-ны өдөр гэрээ байгуулсан. Увс аймгийн нэгдсэн эмнэлгийн өргөтгөлийн барилгын эскиз зургийг дуусган, ЭМЯ-ны ТАХ-аар 10 дугаар сарын 26-ны өдөр хэлэлцүүлж, аймгийн ерөнхий архитектораар батлуулахаар хүргүүлсэн. Барилга архитектурын зургийг 12 дугаар сарын 15-ны өдрийн дотор эцэслэн, ОБЕГ, МХЕГ, БХТ-т хүргүүлэн магадлалд оруулахаар ажиллаж байна.	СЭЗГ-ХОХ I-IV улирал	0
75	2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга	1.Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийн засвар	2021-2024	8,750.0 Улсын төсөв	Тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	“Эрүүл мэндийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө”-нд 387,573.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл, арга хэмжээ тусгаснаас 2022 онд 72,898.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг	СЭЗГ-ХОХ I-IV улирал	70.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээн ний хувь, %
	байгууламж, дэд бүтцийг сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	шинэчлэлтийн ажил хийнэ				санхүүжүүлэхээр баталжээ. Он дамжин хэрэгжиж байгаа 2022 онд дуусгавар болох ёстой 33 барилгаас 22 барилгын ажлын явц 75%-ийн гүйцэтгэлтэй байна. 5 барилгын ажил бүрэн дуусгавар болсон. 11 барилга нь 2022 онд ашиглалтад орох боломжгүй болсон. Энэ нь үнийн өсөлт болон төсөвт өртгийн нэмэгдлээс шалтгаалан 2023 онд шилжсэн болно. 2022 онд шинээр эхлэх 36 барилгаас 25 барилгын ажлын явц 35% байна. 11 барилга технологийн шаардлагаас хамааран ажил зогссон байна.		
76		2.Ундны ус, ариун цэврийн байгууламжийн аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулж, улсын хэмжээнд хэрэгжүүлнэ	2021-2024	27.0 Гадаадын зээл, тусламж	2 аймагт аудит, 4 жижиг суурин газарт УАБТ-г боловсруулах, УАБТ-ний хэрэгжилт 50 хувиас доош байгаа 2 хангагч байгууллагад талбарын сургалт, усны чанар, аюулгүй байдалд эрсдэлийн үнэлгээ хийсэн байна.	2022 онд Орхон аймгийн Жаргалант сум, Архангай аймгийн Эрдэнэмандал, Тариат, Өндөр-Улаан сум зэрэг 4 газар Усны аюулгүй байдлын төлөвлөгөөнд хөндлөнгийн аудит хийсэн. Архангай аймгийн “Ундрага” ХХК болон Орхон аймгийн Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ, Эрдэнэт ус дулаан түгээх сүлжээ зэрэг байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 15-25-ны өдөр талбарын сургалтыг МХЕГ, АШУҮИС, Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах зөвлөл, НЭМҮТ-тэй зохион байгуулж, Усны аюулгүй байдлын төлөвлөгөөг боловсруулсан. ДЭМБ-аас 20,556,585 төгрөгийн санхүүжилтийг гаргасан болно.	НЭМГ-УСХЗХ I-IV улирал	100.0
77	2.1.12. Аймаг, сумын эрүүл мэндийн байгууллага, эмнэлгүүдийн барилга байгууламж, дэд бүтцийг	3.Өрх, сумын эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилгыг шинэчилнэ	2021-2024	9,300.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	Өрх, сумын ЭМТ-ийн барилгын явц 70 хувьтай байна. ХУД, ЧД-ийн нэгдсэн эмнэлгийн барилгын ажил эхэлсэн байна.	Төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 45 шилжих барилга байгаагаас 2022 онд ашиглалтад орох шилжих барилга 33, шинэ барилга 36 байгаагаас 2022 онд ашиглалтад орох шинэ барилга 3, 2022 онд ашиглалтад орох нийт 36 барилга, 161.4 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгээр	СЭЗГ-ХОХ I-IV улирал	50.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	сайжруулан стандарт, чанарын шаардлага хангасан тэгш хүртээмжтэй, чанартай үйлчилгээг үзүүлэх орчныг бүрдүүлнэ.					батлагдсан. Үүнээс нийт 21 өрх, сумын ЭМТ-ийн барилгын барилга угсралтын ажлын явц 75.0 хувьтай байна. Хан-Уул дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын зурагт өөрчлөлт орж, хийгдэж дуусаж байна. Худалдан авах ажиллагаа зохион байгуулагдахаар Үнэлгээний хороо байгуулагдаад байна. Чингэлтэй дүүргийн нэгдсэн эмнэлгийн барилгын газрын асуудлыг шийдвэрлэж байна.		
78		4.Сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн барилга байгууламж, дэд бүтцийн стандарт боловсруулж, хэрэгжүүлнэ	2021-2024	1,300.0 Улсын төсөв	Шаардлага хангасан байгууллагын тоо 80 болсон байна.	Барилга, хот байгуулалтын сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн 03 дугаар тушаалаар Эмнэлгийн барилгын норм, дүрмийг баталсан. 2021 онд шинээр баригдаж байгаа сум, өрхийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн 21 барилга нь энэхүү дүрмийн дагуу баригдаж байна. Мөн шилжих 41 барилга эмнэлгийн барилгын норм, дүрмийн дагуу хянаж байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд нийт 45 шилжих барилга байгууламжийн төсөл хэвийн үргэлжилж байна. Мөн 2022 оны Төсвийн тухай хуульд тусгагдсан 161.4 тэрбум төгрөгийн 36 шинэ барилгын худалдан авах ажиллагааг зохион байгуулагдаж 22 барилгын гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан бөгөөд барилга угсралтын ажил эхлээд байна.	СЭЗГ-ХОХ	70.0
79		5.Эрүүл мэндийн анхан шатны байгууллагын агаарын чанарын дэд бүтцийг сайжруулна	2021-2022	200.0 Гадаадын зээл, тусламж	Монгол гэрийн дулаалга, халаалтын багцыг 50 өрхөд нэвтрүүлсэн байна.	Швейцарын Хөгжлийн Агентлаг, НҮБ-ын Хүүхдийн сангийн хамтарсан санхүүжилттэй "Эх, хүүхдийн эрүүл мэндэд үзүүлэх агаарын бохирдлын нөлөөллийг бууруулах нь" төслийн хүрээнд 09 дүгээр сарын 01-ний байдлаар Баянхонгор аймагт 110, Говь-Алтай аймагт 62, Өмнөговь аймагт 59,	НЭМГ-УСХЗХ I-IV улирал	70.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						Баянзүрх дүүрэгт 40, Сонгинохайрхан дүүрэгт 39 ширхэг Монгол гэрийн дулаалга, халаалтын багцыг иргэд хүлээн авсан байна. Төслийн хүрээнд НҮБ-ын Хүүхдийн сангаас 20 ширхэг Агаарын чанарыг хянах бага оврын төхөөрөмжийг 22 сая төгрөгөөр худалдан авч, 2022 оны 11 дүгээр сарын 03-ны өдөр ЭМЯ-нд хүлээлгэж өгсөн. Төхөөрөмжийг хуваарилах Эрүүл мэндийн сайдын тушаалын төслийг боловсруулж байна.		
80		6.Захиалгын дагуу барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна	2021-2024	Улсын төсөв	Батлагдсан зураг төслийн дагуу холболт хийнэ.	Сумын 10, 15, 22 ортой Эрүүл мэндийн төв, 50 ортой Хүүхдийн эмнэлгийн барилга байгууламжийн нэг маягийн болон давтан хэрэглэх зураг төслийг Нийслэлийн хот байгуулалтын хөгжлийн газраар 2021 онд баталгаажуулж, 21 аймгийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлсэн. 30 ортой сүрьеэгийн эмнэлэг, Зоонозын өвчин судлалын төвийн барилгын нэг маягийн зураг, давтан хэрэглэх зураг төслийг боловсруулсан. Батлагдсан зураг төслийн дагуу 2023 барилга байгууламжууд баригдана.	СЭЗГ-ХОХ	70.0
81	2.1.13. Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.	1.Өрхийн эрүүл мэндийн төвийн эрхзүйн баримт бичигт шинэчлэл хийж, өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршиж, оновчтой хэлбэрийг сонгон нэвтрүүлнэ	2021-2024		Өрхийн эрүүл мэндийн төвийн хувилбаруудыг туршина.	Азийн хөгжлийн банкны Эрүүл мэндийн салбар хөгжил хөтөлбөр-6-ийн “Ядуу эмзэг бүлгийн иргэдэд үзүүлэх тусламж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах” төслийн хүрээнд Өрхийн эрүүл мэндийн төвийн өнөөгийн байдлын үнэлгээг 154 ӨЭМТ-д хийсэн байна. Хөвсгөл, Булган, Дорноговь аймгийн ӨЭМТ-үүдийн үйл ажиллагаатай газар дээр нь очиж танилцсан ба судалгааны үр дүнгийн боловсруулалт хийгдэж байна.	БТГ-СУХ I-IV улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
82	2.1.13. Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.	2.Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний багцыг оновчтой болгож, гүйцэтгэлийн шалгуурын дагуу тусламж, үйлчилгээ, иргэнийг дагасан гүйцэтгэлийн санхүүжилтийг нэвтрүүлнэ	2021-2024	250.0 Улсын төсөв (ЭМДС)	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвд нэвтрүүлсэн байна.	Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвийн санхүүжилтийн журмыг шинэчилж ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор баталж, 2022 оны 04 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлэн ажиллаж байна. Мөн ЭМДҮЗ-ын 13 дугаар тогтоолоор анхан шатны эрүүл мэндийн байгууллагуудын үлгэрчилсэн гэрээ, гэрээний хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлтийг батлуулж сар бүр 80 хувийн урьдчилгаа санхүүжилт олгож, гүйцэтгэлээр 20 хувийг хянаж олгохоор зохицуулсан. Ингэснээр иргэн анхан шатны тусламж, үйлчилгээг хаанаас авч байгааг цахимаар хянаж, тусламж, үйлчилгээ үзүүлж буй анхан шатны эрүүл мэндийн байгууллагыг санхүүжүүлэх боломж бүрдсэн. Хэрэгжилтийн явцад эрүүл мэндийн байгууллагуудын программ хангамж хугацаандаа ашиглалтад ороогүйтэй холбоотой ЭМДҮЗ-ийн 09, 14 дүгээр тогтоолуудыг гаргаж санхүүжилтийг олгож ажилласан.	СЭЗГ-СДХ I-IV улирал	100.0
83	2.1.13. Өрхийн эрүүл мэндийн төвийн статусыг тодорхой болгож, санхүүжилтийг оновчтой хэлбэрээр шийдвэрлэнэ.	3.Эрүүл мэндийн анхан шатлалын тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үйлчлүүлэгчийн хөндлөнгийн үнэлгээний тогтолцоо бүрдүүлэх, ил тод, нээлттэй болгоно	2021-2024	500.0 Улсын төсөв (ЭМДС)	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээнд хөндлөнгийн төрийн бус байгууллагаар үнэлгээ хийгдсэн байна.	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжид үнэлгээ хийж эхлээгүй байна.	ЭТҮГ-АЛШТХ II-III улирал	0
84		4.Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал,	2021-2024			ЭМДҮЗ-ийн 2021 оны 04 дүгээр тогтоол, ЭМДҮЗ-ийн 2019 оны 23 дугаар тогтоолыг нэгтгэж Өрхийн эрүүл мэндийн төвийн төсвийг тооцох аргачлал, санхүүжүүлэх	СЭЗГ-СДХ	100.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
		санхүүжүүлэх, хяналт тавих журмыг шинэчилнэ				журмыг шинэчлэн ЭМДҮЗ-ийн 2022 оны 05 дугаар тогтоолоор батлуулж, 04 дүгээр сарын 01-нээс хэрэгжүүлж эхэлсэн. Шинэчилсэн журмын дагуу нэг иргэнд ногдох нормативт зардлыг 2 дахин нэмэгдүүлж санхүүжилтийг олгож байна.		
85	2.1.14.Нүхэн жорлонтой эмнэлгийг үе шаттайгаар орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болгоно.	1.Эрүүл мэндийн анхан шатны байгууллагуудыг сайжруулсан ариун цэврийн байгууламжтай болгоно	2021-2024	5,000.0 Улсын төсөв, Гадаадын зээл, тусламж	60 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгосон байна.	Ус, ариун цэврийн байгууламжийн түргэвчилсэн үнэлгээний асуумжийг ЭМЯ, НЭМҮТ, МХЕГ хамтран 2022 онд боловсруулж, судалгаа авсан. Ариун цэврийн байгууламж, бохир ус зайлуулах систем, ус хангамж, гарын эрүүл ахуй, эрүүл мэндийн байгууллагын хог хаягдлын менежментийн байдал зэрэг чиглэлээр асуумжийг 21 аймгийн нийт 358 сумын Эрүүл мэндийн төвөөс авч нэгтгэн улсын хэмжээний нөхцөл байдлын талаарх мэдээллийг боловсруулсан. Судалгаанд хамрагдсан сумын ЭМТ-ийн 76.5% нь нүхэн жорлон тогтмол ашигладаг, 13.1% нь хааяа ашигладаг, 2.0% огт ашигладаггүй бол 8.4% нь гадна нүхэн жорлонгүй байна. Нүхэн жорлон ашигладаг байдлыг бүсээр харахад баруун бүсийн сумын ЭМТ хамгийн их буюу 89.2%, зүүн бүс 78.6%, хангайн бүс 78.1%, төвийн бүс 60%-д нүхэн жорлон тогтмол ашигладаг байна. Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд 24,1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 3 аймгийн нийт 15 сумын эрүүл мэндийн төвийг үе шаттайгаар орчин үеийн нүхэн жорлон, ариун цэврийн байгууламжтай болгохоор төсөвлөсөн. Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтад Сумын эрүүл мэндийн төвүүдийн ариун цэврийн байгууламж /Улсын хэмжээнд/ төсөл, арга	НЭМГ-УСХЗХ, СЭЗГ-ХОХ II, IV улирал	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						хэмжээнд 24.1 тэрбум төгрөгийн төсөвт өртөгөөс 2022 онд санхүүжих дүн 360.0 сая төгрөг батлагдсан. Зураг төсөл хийгдэж, магадлалын ерөнхий дүгнэлт хүлээгдэж байна.		
86	2.5.8.Гэр бүл, хүүхэд залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг дээдэлсэн, нийгмийн бүлгийн оролцоог хангасан хүний хөгжлийн цогц бодлого хэрэгжүүлнэ.	5.Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж, үйлчилгээний тогтолцоог нэвтрүүлнэ	2021-2024	300.0 Улсын төсөв	Төлөвлөгөөний хэрэгжилт 30-аас доошгүй хувьд хүрсэн байна.	Ахмад настны эрхийг хангах орон тооны бус дэд зөвлөлийг Эрүүл мэндийн сайдын 2021 оны 12 дугаар сарын 20-ны өдрийн А/792 дугаар тушаалаар батлуулсан. Тус дэд зөвлөлийн хурлаар “Эрүүл, бүтээлч амьдрал, идэвхтэй, насжилтыг дэмжсэн, ахмад настанд ээлтэй, тэгш хүртээмжтэй урт хугацааны тусламж, үйлчилгээний тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр 2021-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-г хэлэлцүүлэхээр бэлдэж байна. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/749 дүгээр тушаалаар “Сэргээн засах тусламж, үйлчилгээг хөгжүүлэх 2021-2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө”-г баталсан. Идэвхитэй насжилтыг дэмжих 3 төвийн үйл ажиллагааг 3 түвшинд (нийслэлийн дүүрэг, аймаг, сум) ХНХЯ-тай хамтарч туршилтын журмаар эхлүүлсэн. Мөн УИХ-ын НББХ-ны 2022 оны 01 дүгээр тогтоолоор Ахмад настны тухай хууль, Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилтийг хянан шалгах ажлын хэсэг байгуулагдсан. Энэхүү ажлын хэсгийн дэд ажлын хэсэгт ЭМЯ, ХНХЯ-ны төлөөлөл орсон бөгөөд арга хэмжээний тайланд үндэслэн НББХ-оос тогтоол боловсруулан гаргахаар ажиллаж байна. Үүнд Геронтологийн үндэсний төвийн барилга, эмнэлгийн мэргэжилтний хангагдаагүй хэрэгцээг шийдвэрлэхэд	ЭТҮГ (ХНХЯ)	50.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээн ний хувь, %
						чиглэсэн санал, Урт хугацааны тусламж, үйлчилгээний санхүүжилтийн тогтолцоог сайжруулахад чиглэсэн саналуудыг өгсөн болно.		
87		7.Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвүүдийг байгуулж, хүн амын бүлгүүдийн онцлогт нийцсэн хөгжлийн үйлчилгээ үзүүлэх орчныг бүрдүүлнэ.	2021-2024	21,000.0 Улсын төсөв	Гэр бүл, хүүхэд, залуучууд, ахмад настны хөгжлийн цогц төвийн үйлчилгээг нийт хүн амын 10-аас доошгүй хувьд хүргэсэн байна.	Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Азийн хөгжлийн банк хамтран хэрэгжүүлж буй бүс нутгийн ТТ-9928 "Олон нийтэд түшиглэсэн урт хугацааны тусламж үйлчилгээний шинэлэг тогтолцоог хөгжүүлэх нь" төслийн хүрээнд "Идэвхитэй насжилтыг дэмжих төвийн стратеги төлөвлөгөө боловсруулах", эхний ээлжинд 3 төвийн үйл ажиллагааг эхлүүлэн турших зорилготойгоор сонгогдсон Сонгинохайрхан дүүргийн "Ачлалт хүүхдүүд" ТББ, Дархан-Уул аймгийн ЗДТГ-ын харъяа "Ахмадын хөгжлийн төв", Сэлэнгэ аймгийн Мандал сумын нэгдсэн эмнэлгийг түшиглэн идэвхитэй насжилтын төвүүдийн үйл ажиллагааг дэмжин стратеги төлөвлөгөөг нь хамтран боловсруулж газар дээр нь очиж ажиллаж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт 5%-тай байна.	НЭМГ, ЭТҮГ (ХНХЯ)	30.0
ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО								
88	4.2.5.Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн	3.Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулна. Төрийн албаны үнэт зүйл, зарчим, манлайллыг өдөр тутмын үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх талаар	2021-2024		Сургалт, сурталчилгааг явуулснаар үнэт зүйл, үндсэн зарчмаа хэрэгжүүлж, манлайллыг хангаснаар ёс зүйн зөрчил буурна.	Салбарын хэмжээнд төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн үйл ажиллагаанд баримтлах ёс зүйн нийтлэг хэм хэмжээг тогтоосон журмыг хэвшүүлэх, төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиулах, манлайллыг хөгжүүлэх талаар ажлууд хийгдэж байна. • Ёс зүйн алдаа зөрчлийг бүртгэх, мэдээлэх, хариу арга хэмжээ авах арга хэмжээг хэвшүүлсэн. • Төрийн албан хаагчийн гүйцэтгэл, үр дүн, төрийн байгууллагын бүтээмжийг	ТЗУГ I-IV улирал	70.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	алба хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана.	сургалт, сурталчилгааны хөтөлбөрийг батлуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана (Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм)				<p>дэмжих, манлайллыг төлөвшүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлөөс Пүрэв гаригийн сургалтад харьяа 2 агентлагийн 150 гаруй албан хаагч, харьяа эрүүл мэндийн байгууллагын удирдлагууд 120 орчим ажилтан тогтмол хамрагдаж байна.</p> <ul style="list-style-type: none"> • Хувь хүний ур чадвар, мэдлэг, хандлагыг зөв эерэг төлөвшлийг бий болгох зорилгоор “Хувь хүний хөгжлийг дэмжих, манлайллыг хөгжүүлэх” сургалтыг ТББ-тай хамтран зохион байгуулж, сургалтад ЭМЯ болон ЭМДЕГ, ЭЭХХЗГ-ын нийт 160 гаруй албан хаагчид тус тус хамрагдсан. • Төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагын эрх бүхий албан тушаалтан хууль тогтоомжид заасан тохиолдолд тухайн салбар, байгууллагын чиг үүргийн онцлогийг харгалзан албан хаагчийн мэргэжлийн ёс зүйн дүрмийг батлан мөрдүүлж болно гэж журамд заасны дагуу байгууллагын хэмжээнд мөрдүүлэх дүрмийг батлуулан үйл ажиллагаандаа хэвшүүлсэн. • Удирдлага болон ажилтнууд хоорондын харилцан итгэлцлийг төрүүлэх, манлайллын хэлбэр болох бусдад үлгэрлэх, чиглүүлэх бусдыг сэдэлжүүлэх, өөрчлөлтийг хийх, шинэлэг арга барилаар ажиллах сэдлийг төрүүлэх зорилгоор Салбарын удирдах ажилтны зөвлөгөөнийг шинэлэг хэлбэрээр зохион байгуулан, онол практикийг хослуулан мэдээллийг хүргэсэн. <p>- 2021-2022 онд шинээр томилогдсон албан хаагчдад яамны Ёс зүйн зөвлөлтэй</p>		

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
						<p>хамтран ажлын байрны сургалтыг 2022 оны 06 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулан, нийт 22 албан хаагчийг хамруулж, сургалтаар албан тушаалд тавигдах шаардлага болон ажиллах нөхцөл, албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг тогтоосон эрх зүйн актыг таниулах, шинэчлэгдсэн дотоод журам, Төрийн албаны тухай хууль, төрийн албан хаагчийн ёс зүй, харилцаа хандлага, байгууллагын соёл, манлайлал сэдвүүдийг хамруулсан.</p> <p>- Эрүүл мэндийн яамны дэргэдэх Эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хорооноос тавьсан хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн удирдах ажилтны сургалтад эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн харилцаа, хандлага, эерэг уур амьсгал бүрдүүлэх чиглэлийн сургалтыг 12 дугаар сарын 5-6-нд хамтран зохион байгуулахаар бэлтгэлийг хангаад байна. Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд өөрчлөлт оруулах ажлын хэсэгт удирдах ажилтныг оролцуулахаар ТАЗ-д санал тавьж шийдвэрлүүлсэн.</p>		
ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО								
89	5.1.4.Гэр хороолол болон аялал жуулчлалын бүсэд "Экожорлон" хэмжээг хэрэгжүүлж, хөрсний	2.Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний байгууллагуудын ариун цэврийн байгууламжийг стандартын шаардлага хангуулна	2021-2024	80.0 Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт, /Хувийн хэвшил/ Гадаадын зээл, тусламж	Аялал жуулчлалын бааз болон худалдаа, үйлчилгээний бусад байгууллагуудын жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна.	Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн 66 дугаар тогтоолоор Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахалтай тэмцэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд тогтоосон гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэргийг цуцлан, шар түвшинд шилжсэнээр Олон улсын зорчих хөдөлгөөн нээлттэй болсонтой холбогдуулан аялал	НЭМГ (БОАЖЯ)	30.0

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Төсөв, 2022 он (сая төгрөг), Эх үүсвэр	2022 онд хүрэх түвшин, үр дүнгийн үзүүлэлт	Хүрсэн түвшин, үр дүн Зарцуулсан санхүүжилт, эх үүсвэр	Хариуцах газар, хэлтэс	Үнэлгээний хувь, %
	бохирдлыг бууруулна.					жуулчлалын үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуй нэгжид зориулан эрүүл ахуй, халдвар хамгааллын зөвлөмж боловсруулан Байгаль орчин, аялал жуулчлалын яаманд 2/2382 албан тоотой хүргүүлж ажилласан. Дэлхийн жорлонгийн өдрийг тохиолдуулан 2022 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр "Далд бохирдолд анхаарцгаая" орчны эрүүл мэндийн асуудлаарх салбар хоорондын хэлэлцүүлгийг ХӨСҮТ, АШУҮИС, УСУГ, Боловсролын судалгааны үндэсний хүрээлэн, Газар зүй, геоэкологийн хүрээлэн болон ACF, UNHABITAT зэрэг олон улсын байгууллага, ТББ, аймаг орон нутаг, нийслэлийн эрүүл мэндийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан зохион байгуулсан.		
ҮНЭЛГЭЭНИЙ ХУВЬ								60.6

Эрүүл мэндийн яам
2022 оны 11 дүгээр сар